Хавсралт

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
## (2021 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнав)

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2021-06-29 Улаанбаатар хот

| Шийд-вэрийн д/д | Зүйл, заал-тын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалтын дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч буй шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| **Нэг. Монгол Улсын хууль** | | | | | |
| 1 | 1 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>7.1.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, эохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Байгууллагын цахим хуудас https://pcsp.gov.mn, нийгмийн сүлжээний фэйсбук хуудас https://www.facebook.com/pcsp.gov.mn -ны мэдээлэл, мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, бүтэц зохион байгуулалт, хэлтэс албаны мэдээлэл, албан хаагчдын болон үйл ажиллагааны цаг үеийн мэдээлэл, даргын тушаал, газрын тогтоол шийдвэрүүдийг тухай бүрд нь байршуулсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| | 2 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>7.1.2. Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Байгууллагын цахим хуудас https://pcsp.gov.mn, нийгмийн сүлжээний фэйсбук хуудас https://www.facebook.com/pcsp.gov.mn -ны мэдээлэл, мэдээллийн самбарт үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн мэдээлэл, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг тухай бүр шинэчлэн оруулсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| | 3 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай** | **ТӨБЗГ – МТА, Хэлтсүүд** | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2011-06-16, Дугаар 2011.06.16<br>7.1.3. Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Байгууллагын цахим хуудас https://pcsp.gov.mn, нийгмийн сүлжээний фэйсбук хуудас https://www.facebook.com/pcsp.gov.mn -ны мэдээлэл, мэдээллийн самбарт Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг тухай бүр шинэчлэн оруулсан. | | |
| | 4 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>7.1.4. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | **ТӨБЗГ – МТА, Хэлтсүүд**<br>Байгууллагын цахим хуудас https://pcsp.gov.mn, нийгмийн сүлжээний фэйсбук хуудас https://www.facebook.com/pcsp.gov.mn -ны мэдээлэл, мэдээллийн самбарт үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тухай бүр шинэчлэн оруулсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| | 5 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>7.1.5. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; | **ТӨБЗГ – МТА, ХЭЗХ**<br>Байгууллагын цахим хуудас https://pcsp.gov.mn, нийгмийн сүлжээний фэйсбук хуудас https://www.facebook.com/pcsp.gov.mn -ны мэдээлэл, мэдээллийн самбарт шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг тухай бүр шинэчлэн байршуулан мэдээлж байна.<br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 29 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, судалгаа хийх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.<br>Хуулийн төслийг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нартай хамтран боловсруулж, ажлын хэсгийн гишүүдийн гаргасан саналыг төсөлд тусгасан.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон үзэл баримтлалын төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд танилцуулж байна. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| | 6 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>7.1.6. Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | **ТӨБЗГ – ТӨБАХ, ТӨУЗХ**<br>Энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авах талаар дотоод үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулалтын нэгж хоорондын уялдаа холбоог хангаж, санал солилцох, уулзалт хийх, санаа, санаачилга гаргах ажлыг өрнүүлж байна.<br>Байгууллага болон Захиргаа, удирдлагын хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын үйл ажиллагааг олон | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нийтээр үнэлүүлэх санал асуулга зохион байгуулж, үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авахаар төлөвлөсөн. Уг ажлыг оны сүүлийн хагас жилд гүйцэтгэнэ. | | |
| | 7 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>7.1.7. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; | **ТӨБЗГ – МТА, Хэлтсүүд**<br>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа төрийн чиг үүргийн ажил, үйлчилгээ байхгүй. | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | Хамаарах үйлчилгээ байхгүй тул хасуулах саналтай |
| | 8 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>7.1.8. Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | **ТӨБЗГ – МТА, Хэлтсүүд**<br>ТӨБЗГ нь тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодоггүй болно. | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | Хамаарах үйлчилгээ байхгүй тул хасуулах саналтай |
| | 9 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>7.1.9. Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх; | **ТӨБЗГ – МТА, ЗУХ**<br>Улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр одоогоор байхгүй болно. | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |
| | 10 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай** | **ТӨБЗГ – МТА, ЗУХ** | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2011-06-16, Дугаар 2011.06.16<br>8.1.1. Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах; | 2021 оны эхний хагас жилд сул орон тоог зарлан мэдээлэх шаардлага үүсээгүй. | | |
| | 11 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>8.1.2. Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | **ТӨБЗГ – МТА, ЗУХ**<br>Байгууллын цахим хуудас https://pcsp.gov.mn, мэдээллийн самбарт албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн байршуулсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 12 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>8.1.3. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | **ТӨБЗГ – МТА, ЗУХ**<br>Байгууллын цахим хуудас https://pcsp.gov.mn, мэдээллийн самбарт хүний нөөцийн стратеги, хөтөлбөр, байгууллага, нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг шинэчлэн байршуулж мэдээлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 13 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>8.1.4. Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | **ТӨБЗГ – МТА, ЗУХ**<br>Байгууллын цахим хуудас https://pcsp.gov.mn, мэдээллийн самбарт хүний нөөцийн удирдлагын мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шинэчлэн мэдээлсэн. Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн, сургалтад хамрагдсан байдал, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт, Авлигатай тэмцэх газраас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлт, сул орон тооны зар гэх мэт мэдээллийг тухай бүр хууль тогтоомжийн дагуу шинэчлэн мэдээлж, нээлттэй байдлыг ханган ажиллав. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 14 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай**<br>2011-06-16, Дугаар 2011.06.16<br>8.1.5. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа | **ТӨБЗГ – МТА, ЗУХ**<br>Байгууллын цахим хуудас https://pcsp.gov.mn, мэдээллийн самбарт албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг байршуулан мэдээлэх арга хэмжээ авсан.<br>Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх. | түвшинг үнэлэх журам"-ын 1.2, 4.1, 4.2 дахь заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлалыг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2021 оны А/53 тушаалаар Үнэлгээний баг байгуулан албан хаагчдын 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэхээр ажиллаж байна. | | |
| 2 | 15 | **Хууль тогтоомжийн тухай /Шинэчилсэн найруулга/**<br>2015-05-29, Дугаар 2017.01.01<br>49.1. Улсын Их Хурал, Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж, холбогдох бүтцийн нэгжийг ажиллуулна. | **ТӨБЗГ – ХЭЗХ, ЗУХ**<br>Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүргээс худалдан авах ажиллагааны чиг үүргийг салгаж, Төрийн худалдан авах ажиллагааны газар байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор байгууллагын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орж, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар 3 хэлтэс, 2 албатай, нийт "31" орон тоотой байхаар баталсан. Уг бүтцийн өөрчлөлтөөр Хууль, эрх зүйн албыг байгуулснаар байгууллагаас гарах аливаа шийдвэр хууль тогтоомжид нийцсэн, эрх зүйн үндэслэл бүхий байх, түүний хэрэгжилтэд байнгын хяналт тавих боломж бий болсон. Улмаар Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын орон тоо нэмэгдэн "55" болж, Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар бүтцэд дахин өөрчлөлт орсон бөгөөд Хууль, эрх зүйн албаны орон тоог нэмэгдүүлж, Хууль, эрх зүйн хэлтэс болгон өргөжүүлэх, чадавхыг сайжруулах арга хэмжээ авсан. Түүнчлэн, Захиргаа, удирдлагын нэгжид хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан чиг үүрэг бүхий албан тушаалыг шинээр бий болгосон. Ингэснээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд холбогдох нэгжүүдээс хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, энэ чиглэлээр хамтран ажиллах тогтолцоо бүрдсэн үр дүнтэй байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналт-таас хасах саналтай. |
| 3 | 16 | **Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/**<br>2017-12-07, Дугаар 2019.01.01<br>55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны А/107, А/108 дугаар тушаалаар батлагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын сургалтын хөтөлбөр, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дуус ч байгаа тул Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дэх хэсэгт заасны дагуу уг хөтөлбөрүүдийг | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | шинэчлэн боловсруулах ажлыг байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2021 оны А/29 дугаар тушаалаар 2021 оны сургалтын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. Уг төлөвлөгөөний дагуу дараах сургалтуудад 2021 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 42 албан хаагчийг хамруулж чадавхыг дээшлүүлсэн байна. Үүнд:<br>– Удирдлагын академиас зохион байгуулсан Тэргүүн түшмэлийн багц сургалтад 1 албан хаагчийг;<br>– Удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ. “Алсын хараа-2050” сэдэвт 40 цагийн богино хугацааны зайн сургалтад 11 албан хаагчийг;<br>– Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагчийг;<br>– Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2 албан хаагчийг;<br>– Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагчийг;<br>– “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-аас зохион байгуулсан “Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга” нарт зориулсан Компанийн засаглалын богино хугацаат сургалтад 16 албан хаагчийг;<br>– Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн шинэчлэлтэй холбоотойгоор Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газар хамтран зохион байгуулсан “Төрийн албаны тухай болон Архив, бичиг хэргийн хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт арга зүйн цахим сургалтад 4 албан хаагчийг;<br>– Төрийн албаны шинэтгэл, “Төрийн албаны хүний нөөцийн удирдлагад цогц чадамжийн хүрээг нэвтрүүлэх нь” дэд төслийн ажлын хүрээнд “Цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сэдэвт сургалтад 2 албан хаагчийг;<br>– ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан хяналт, шинжилгээ, үнэлгээ сургалт” цахим сургалтад 1 албан хаагчийг;<br>– Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг тайлагнах цахим системийн сургалтад 1 албан хаагчийг. | | |
| 4 | 17 | **Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/** | **ТӨБЗГ – ЗУХ** | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хянал- |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2020-05-07, Дугаар 2020.07.01<br><br>21.5. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр анхааран ажиллаж, Засгийн газар, Ерөнхий сайдын шийдвэрээр бүтцийн өөрчлөлт хийх хүрээнд зохион байгуулалтын бүтцийн холбогдох нэгжид хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын орон тоог шинээр бий болгоод байна. Ингэснээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг хангах, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг мөрдөн ажиллах зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлээд байна.<br><br>Тус байгууллага хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтыг дээр дурдсан журамд заасан хугацаа, хуваарийн дагуу Засгийн газар болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байна. | | таас хасах саналтай. |
| | | **МУ-ын хууль: 4 хуулийн 17 заалт:** | **100% - 10 заалт; 70% - 2; ҮБ/ХБ. – 5; Хэрэгжилтийн хувь – 95.0 %.** | | |
| **Хоёр. УИХ-ын тогтоол** | | | | | |
| 5 | 18 | **Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br><br>2014-06-05, № 41<br><br>1.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан компанид төрийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг энэ хуульд нийцүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т, Санхүүгийн зохицуулах хорооноос өмнө баталсан холбогдох журам, заавартз зохих өөрчлөлт оруулахыг Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ыг батлан мөрдөж байна. Журмын 1.3.-т "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг төр тухайн хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх гишүүнээр томилсон этгээдээр дамжуулан хэрэгжүүлнэ" гэж заасан. Засгийн газрын 2017 оны 123 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 245, 335 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 47, 175, 234, 237 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна.<br><br>Цаашид хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслүүд батлагдсаны дараа холбогдох журмуудыг өөрчлөх зайлшгүй шаардлага шинээр үүс ч байгаа болно. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хянал-таас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | 19 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-11-17, № 69<br>4/1. Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх; (4/ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн менежментийг сайжруулах чиглэлээр) | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>2016 онд төрийн өмчийн ногдол ашиг болох 4.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байсан ба төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын менежментийг сайжруулан, ашиг, орлогыг нэмэгдүүлсний үндсэн дээр 2017 онд 12.6 тэрбум төгрөгийн, 2018 онд 42.2 тэрбум төгрөгийн, 2019 онд 155.0 тэрбум төгрөгийн, 2020 онд 173.8 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. 2021 онд 184.5 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | 2017 оны жилийн эцсийн тайлангаар хяналтаас хасч байсан.<br>Цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 20 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-11-17, № 69<br>4/2.2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар баталгаажсан 10.8 их наяд төгрөгийн өглөгийг бууруулах; (4/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн менежментийг сайжруулах чиглэлээр) | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүд нийт өглөг 2015 онд 10,769.4 тэрбум төгрөг байсан бол 2017 оны гүйцэтгэлээр 9,501.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7 хувь буюу 1,268.0 тэрбум төгрөгөөр буурсан дүнтэй байсан.<br>2019 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийт өглөг 4,154.0 тэрбум төгрөг, 2020 оны жилийн эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 3,883.2 тэрбум төгрөг болж буурсан үзүүлэлттэй байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | 2017 оны жилийн эцсийн тайлангаар хяналтаас хасч байсан.<br>Цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 21 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-11-17, № 69<br>4/3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зардлыг багасгах, тэдгээрт ажиллагсдын тоог бууруулан 2012 оны түвшинд хүргэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зардлыг багасгах, тэдгээрт ажиллагсдын тоог бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалттай холбоотойгоор ажиллагсдын тоо төдийлөн буурахгүй байна. 2018 онд 43830, 2019 онд 43990.0, 2020 онд 50331.0 ажиллагсад ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | 2017 оны жилийн эцсийн тайлангаар хяналтаас хасч байсан.<br>Цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 22 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-11-17, № 69<br>4/4.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл голлон ордог зарчимд шилжих; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл голлон ордог зарчимд шилжих зорилтыг бүрэн хэрэгжүүлсэн. Жишээ нь: Эрчим хүчний салбарын компанийн ТУЗ-ийн 9 гишүүний 4-5 гишүүн нь тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төлөөлөл хэрэгжүүлж байгаа.<br>2020 оны жилийн эцсийн байдлаар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 51 компанийн 39 төлөөлөн удирдах зөвлөлд нийт 347 хүн гишүүнээр ажиллаж байгаагаас 111 нь хараат бус гишүүнээр, 236 гишүүн нь төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэн ажилласан. ТУЗ-ийн 70 гаруй гишүүн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас, 166 орчим нь бусад төрийн захиргааны байгууллагаас томилогдсон албан хаагчид төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэн ажиллаж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | 2016 оны жилийн эцсийн тайлангаар хяналтаас хасч байсан.<br>Цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 23 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-11-17, №69<br>4/5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, удирдлагын цалин, урамшууллыг оновчтой тогтоох. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай" 41 дүгээр тэмдэглэлд нэг сарын 5.0-10.0 сая төгрөгийн цалин хөлстэй этгээдийн цалингийн хэмжээг 30 хувиар бууруулах гэж заасны дагуу 2016 онд энэ шатлалд хамрагдах цалинтай 13 хуулийн этгээдийн удирдлагын цалинг бууруулах үүрэг даалгаврыг өгч, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, удирдлагын цалин, урамшууллыг нэмэгдүүлэхгүй байх чиглэл баримтлан ажиллаж ирсэн.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 онд төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлагын цалин хөлс, урамшууллын тогтолцоог шинэчлэн мөрдүүлэх арга хэмжээ аван ажиллав. Энэ хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын цалин хөлс, урамшууллыг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, улсын төсөвт төвлөрүүлсэн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлалыг ТӨБЗГ-ын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам"-ын 3 дугаар хавсралтад тодорхой зааж, уг журмыг мөрдүүлэх арга хэмжээ авсан. ТӨБЗГ-аас ТӨҮГ-ын захиралтай | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | 2017 оны жилийн эцсийн тайлангаар хяналтаас хасч байсан.<br>Цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байгуулах, төрийн өмчит компанийн ТУЗ-өөс компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактад цалинг уг аргачлалын дагуу тооцон мөрдүүлж байна. ТӨБЗГ-аас төлөөлөл хэрэгжүүлж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газар энэхүү журмыг бүрэн хэрэгжүүлж байгаа болно. | | |
| 7 | 24 | **Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай**<br>2019-09-13, №74<br>1.Монгол Улсын Их Хурлын 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн "Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 23 дугаар тогтоол болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Н05/05 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор "Эрдэнэт үйлдвэр", "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газруудад тогтоосон онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ-т онцгой дэглэм тогтоосон хугацааны үйл ажиллагааны үр дүнгийн талаар Засгийн газарт танилцуулсан. Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэл гарч, тус үйлдвэрийн газруудад тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг сайжруулан үйлдвэрлэл, эдийн засгийн зорилтуудыг хангаж биелүүлж, үр дүн гаргасан байдлыг нь тодорхой тоо баримтаар дурдаж, сайшаан тэмдэглэсэн.<br>Засгийн газрын 2020 оны 56 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, "Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК (хуучин нэрээр)-ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авах гэх талтай хэлцэл хийн, санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн саналыг хэлэлцэн шийдвэрлэх хүртэл онцгой дэглэмийн үед авч хэрэгжүүлж байсан ажлыг үргэлжлүүлэн үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг ердийн горимоор ажиллуулах арга хэмжээ авсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | Онцгой дэглэмийг дуусгавар болгох, түүнтэй холбоотой Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоол, 56 дугаар тэмдэглэл гарсан тул цаашид хяналтаас хасах саналтай байна. |
| | 25 | **Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай**<br>2019-09-13, №74<br>2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/, тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т тус тус үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Тогтоолын хэрэгжилтийг хуулийн хүрээнд зохион байгуулж ажилласан. Онцгой дэглэмийн үеийн сар, улирлын мэдээллийг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо болон ЗГХЭГ-т тухай бүр мэдээлж, холбогдох материалыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ болон ТӨБЗГ-ын зүгээс хүргүүлж ажилласан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | Онцгой дэглэмийг дуусгавар болгох, түүнтэй холбоотой Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоол, 56 дугаар тэмдэглэл гарсан тул цаашид |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хяналтаас хасах саналтай байна. |
| 8 | 26 | **Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай**<br>2020-01-10, №04<br>1.1/. Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:<br>1/төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд "Эрдэнэс силвер ресурс" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг судалж, саналаа холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн хамт Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Эрдэнэс Монгол" ХХК-ийн удирдлага, менежментийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт харьяалан хариуцдаггүй тул энэ тогтоолын хэрэгжилт шууд хамаарахгүй байна. | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | Хамаарал -гүй тул хяналтаас хасах саналтай. |
| 9 | 27 | **Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>2020-12-04, № 39<br>1.5/. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг "Эрдэнэт" ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 677 дугаар тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө баталсан. Уг зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг тусган баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| | | **УИХ-ын тогтоол: 5 тогтоолын 10 заалт.** | **100% - 9 заалт, ХБ/ҮБ – 1 заалт, Хэрэгжилтийн хувь – 100%.** | | |
| **Гурав. УИХ-ын Байнгын хорооны тогтоол** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 28 | **Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний тухай**<br>2012-12-06, № 05<br>БОХХААБХ<br>1.Уулын баяжуулах "Эрдэнэт үйлдвэр" ХХК-д: Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байгаль орчныг хамгаалах ажил болон Орхон – Сэлэнгийн сав ба бусад нутгийг бохирдуулж буй цагаан тоосыг дарах үйл ажиллагаанд салбарын эрдэмтдийг татан оролцуулж, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр даруй гүйцэтгэх. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь ШУА-тай хамтын ажиллагааны хүрээнд байгаль орчны чиглэлээр "Цагаан тоосны тархалтын загварчлал"-ын ажлыг хийж байна.<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, дарах зорилгоор 1/хаягдал булингыг даргач бодистой барьцалдуулан тоосыг дарах, 2/тоос даргач бодисыг устай хольж тусгай зориулалтын техник тоног төхөөрөмж ашиглан тоостой талбайд цацах, 3/үйлдвэрийн технологийн гэсэн гурван аргыг хослуулан 2020 онд Хаягдлын аж ахуйн талбайн тоос идэвхтэй дэгддэг 900 га хуурай талбайн 80 хувь буюу 720 га талбайн тоосжилтыг дарсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| 11 | 29 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, №15<br>ЭЗБХ<br>1.7/ Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалт, үр ашгийг сайжруулах үүднээс төрийн өмчийн хувьчлалыг үе шаттай, зохистой зохион байгуулах, ард иргэдэд үзүүлэх нийгмийн салбарын хүртээмж, үр өгөөжийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авах. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>ТӨБЗГ-аас 2018 онд "Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Тус төслийг тухайн үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг Улсын Их Хуралд 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр өргөн барьсан. Улсын Их Хурлаас саналыг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасан.<br>Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын "Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай" тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан. | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |
| | 30 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, №15<br>ЭЗБХ<br>2.Энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг 2017 онд багтаан УИХ-ын ЭЗБХ-д танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Улсын Их Хурлын 2018 оны нэгдсэн хуралдаанаар "Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн төслийг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд Дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасантай холбогдуулан Б.Жавхлан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгт ТӨБЗГ-аас холбогдох мэдээллийг гарган хүргүүлж | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байсан. Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр "Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэрлэсэн.<br>"Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдаагүй, хувьчлалын асуудлаар тодорхой бодлого, чиглэл гараагүй байна. | | |
| 12 | 31 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, №16<br>ЭЗБХ<br>2.4/.Төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьцааг хөрөнгийн биржээр олон нийтэд арилжаалах, санхүүжилт босгохтой холбоотой үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Монголын цахилгаан холбоо" ХК-ийн хувьцаа эзэмшигч БНСУ-ын "Кореа Телеком" корпорацийн өөрийн эзэмшлийн 40 хувь буюу 10,348,111 ширхэг хувьцааг Монголын Улсын Засгийн газарт гэрээний дагуу санал болгосныг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 300 дугаар тогтоолоор худалдаж авах шийдвэр гаргасан. Уг тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан багцын арилжаа явагдаж "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн төрийн эзэмшлийн хувь 94.67 хувь болон өөрчлөгдсөн. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| | 32 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, №16<br>ЭЗБХ<br>2.5/. Санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын хөрөнгө оруулалттай байгууллагуудын хяналт, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх, давхардлыг арилгахад хамтран ажиллах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зарим төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн менежментийг сайжруулах, зардлыг бууруулах, үйл ажиллагааны давхардлыг арилгах, ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт санал хүргүүлж, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай" 9 дүгээр тогтоолыг гаргуулж, "Авто замын тоног төхөөрөмжийн түрээс" ТӨХК, "Аж үйлдвэрийн цогцолбор" ТӨХК, "Монгол тамга" ТӨҮГ, "Монгол тариалан" ТӨҮГ, "Монгол мах" ТӨҮГ-ыг татан буулгах ажлыг зохион байгуулсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| 13 | 33 | **Чиглэл өгөх тухай**<br>2018-04-25, Дугаар 2018 №08<br>ЭЗБХ<br>2.3/ Төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай хамтран статистикийн мэдээллийн чанар, үнэн зөв байдалд хяналт шалгалт хийх, шат шатны хариуцлагыг | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны статистикийн мэдээллийг нийслэл, 21 аймаг, төрийн өмчит 6000-аад хуулийн этгээдээс цуглуулан авч нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 5 дугаар сард багтаан хүргүүлсэн. Мэдээллийн чанарыг сайжруулах, цахим хэлбэрээр тайлагнах боломжийг бий болгох чиглэлээр програм хангамжийн бодлогын даалгаварт тусгах, ҮСХ-ноос зөвлөмж авах, МХХТГ-тай хамтран ажиллаж, | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | өндөржүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах; | мэдээллийн санг бүрдүүлэх тайлагнах хугацаа, хэлбэрийг өөрчлөх талаар тодорхой саналууд гарган идэвхтэй ажиллаж байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан 2 албан хаагч Статистикийн улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |
| 14 | 34 | **Чиглэл өгөх тухай**<br>2018-05-02, №10<br>ЭЗБХ<br>1.11/ Төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргах, санхүүжилт босгохтой холбоотой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцаа эзэмшигч БНСУ-ын “Кореа Телеком” корпорацийн өөрийн эзэмшлийн 40 хувь буюу 10,348,111 ширхэг хувьцааг Монголын Улсын Засгийн газарт гэрээний дагуу санал болгосныг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 300 дугаар тогтоолоор худалдаж авах шийдвэр гаргасан. Уг тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан багцын арилжаа явагдаж “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн төрийн эзэмшлийн хувь 94.67 хувь болон өөрчлөгдсөн. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | | **УИХ-ын Байнгын хорооны тогтоол:**<br>**5 тогтоолын 7 заалт** | **100% - 3 заалт; 70% - 2 заалт; ХБ/ҮБ - 2 заалт; Хэрэгжилтийн хувь – 88.0 хувь.** | | |
| | | **Дөрөв. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | |
| 15 | 35 | **Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай**<br>2018-05-23, №46<br>3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, идэвх санаачилгыг өрнүүлэх талаар нийт албан хаагчдад сурталчлан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн үзэл санааг дэмжин дэлгэрүүлэхэд анхааран ажиллаж байна. Байгууллагын мэдээллийн самбарын зарим хэсгийг монгол, крилл бичгээр хослуулан бичиж, сурталчлан таниулах ажлыг хийсэн. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | | **Ерөнхийлөгчийн зарлиг:**<br>**1 зарлигийн 1 заалт.** | **70% - 1 заалт, Хэрэгжилтийн хувь – 70 %** | | |
| | | **Тав. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж** | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | 36 | **Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай**<br><br>2017-07-19, №19/5<br><br>1.Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт энэ чиглэлээр үүссэн гомдол, маргаан бүртгэгдээгүй. Олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг анхаарч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.<br><br>Энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг дараах удирдлага, чиглэлээр ханган ажиллав. Үүнд:<br><br>– Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн "Монголбанканд гадаад валют худалдах зарим арга хэмжээний тухай" 03/03/А5 дугаар хамтарсан тушаалаар Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн үйл ажиллагааны явцад бий болсон гадаад валютыг Монголбанкны тухайн өдрийн зарласан ханшаар Монголбанкинд худалдаж байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан. Хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангуулахаар ТӨБЗГ-ын 2019 оны 01-р сарын 14-ний өдрийн "Тушаалын хэрэгжилтийг хангуулах тухай" А-1/89 дүгээр албан бичгийг нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 94 хуулийн этгээдэд хүргүүлсэн. 2020 оны тайлант хугацааны байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс нийт 1,067,012,600.0 ам.доллар ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ – 657,500,000.0 ам.доллар, "Монголросцветмет" ТӨҮГ – 46,300,000.0 ам.доллар, "Эрдэнэс Тавантолгой" ХХК – 363,212,600.0 ам.доллар)-ыг Монголбанкинд арилжсан дүнтэй байна.<br>– Төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын мөнгөн урсгал, түүний хөдөлгөөнд хяналт тавьж, Монголбанкины зохист шалгуур хангасан арилжааны банкинд тухайн компани, үйлдвэрийн газрын чөлөөт мөнгөн үлдэгдлийг байршуулж чиглэл өгч ажилласан.<br>Төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын хандив, тусламж, зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг тухайн компани, үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг дүгнэх явцад тухай бүр хяналт тавьж байгаа болно. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | Хэвшсэн тул цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 17 | 37 | **Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын талаар авах арга хэмжээний тухай**<br>2020-11-13, №26/16<br>1.Дэлхий нийтэд тархаад байгаа коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал иргэдийн дунд илэрч, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан гамшгийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг бууруулах, цар тахлын халдварын тархалтыг зогсоох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг шуурхай зохион байгуулах. | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ, Шуурхай штаб**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, Засгийн газар, Улсын Онцгой комисс болон холбогдох мэргэжлийн байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэн цар тахлын нөхцөлд эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагааг тусгай горимд шилжүүлж, 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй албан хаагчдаас бусад албан хаагчдын ажиллах хуваарийг батлан, Засгийн газрын баталсан түр журмын дагуу албан хаагчдын ажлын байранд ажиллах тоог цөөрүүлэн ээлжээр ажиллуулж байна. Бүх нийтийн хол хорио тотоосон үед батлагдсан хуваарийн дагуу ээлжээр ажиллахаас бусад үед албан хаагчид гэрээсээ цахимаар ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ аван төрийн байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллав. Хурал, уулзалт, сургалт семинар, сурталчилгааны ажлыг цахим хэлбэрээр хийх техникийн шийдлийг бий болгон зайнаас, цахимаар зохион байгуулж ажиллав. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | Хэвшиж байгаа ажил тул цаашид хяналтаас хасах саналтай. |
| | | **ҮАБЗ-ийн 2 зөвлөмжийн 2 заалт:** | **100 % - 2 заалт, Хэрэгжилтийн хувь – 100%.** | | |
| **Зургаа. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 18 | 38 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулах тухай**<br>2013-10-05, № 336<br>3.Монгол Улс ба Нордикийн хөгжлийн сан хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдлийн тооцоог гаргаж баталгаажуулах, Автотээврийн үндэсний төвтэй дамжуулан зээлдүүлэх гэрээг шинэчлэн байгуулж зээлийн эргэн төлөлтийг тус төвийн жил бүрийн зорилтот түвшинд тусган барагдуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Зам, тээврийн сайд А.Гансүх нарт даалгасугай. | **ТӨБЗГ - ТӨУЗХ**<br>2001 онд 3,940,000.0 SDR–тэй /ЗТЭ/ тэнцэх зээлийг Тээвэр хөгжүүлэх төслийн хүрээнд хуучнаар Санхүү, эдийн засгийн яам ба Авто тээврийн газрын хооронд байгуулсан NDF-353 дугаартай гэрээний дагуу Нордикийн хөгжлийн сангаар дамжуулан зээлийг олгосон. Санхүү, эдийн засгийн яам (хуучнаар), Авто тээврийн газрын хооронд 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан 122/11/55/ дугаар гэрээний хавсралт дахь дамжуулан зээлдүүлэхэд өөрчлөлт оруулан зээлийн төлбөрийн хуваарийг шинэчлэн, зээлийг төлж эхэлсэн.<br>"Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын жил бүрийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусган зээлийн төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажилласан.<br>2020 оны эхний хагас жилийн төлбөр болох 67,786.5 SDR /ЗТЭ/ буюу 263.6 сая төгрөгийг 2020.06.19-ны өдөр Сангийн яамны Төрийн сангийн дансанд, мөн 2020 оны сүүлийн хагас жил болон 2021 оны бүтэн жилийн төлбөр болох 201,560.13 SDR буюу нийт 807.3 сая төгрөгийг 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдөр тус тус | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төлсөн. Үүний 179,964.00 SDR буюу 720.8 сая төгрөг нь үндсэн зээлийн төлбөр 21,696.13 SDR буюу 86.9 сая төгрөг нь хүүгийн төлбөр болно. 2021 оныг дуустал зээлийн үндсэн төлбөр болон хүүг төлж дуусгасан.<br>Зээлийн нийт үлдэгдэл 1,439,754.01 SDR буюу 5.6 тэрбум төгрөг байна. | | |
| 19 | 39 | **Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай**<br>2017-02-01, № 42<br>1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн зээлийн багцыг Хөгжлийн банкнаас Засгийн газарт шилжүүлэхтэй холбогдуулан төсөл санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн банктай байгуулсан холбогдох зээлийн гэрээг дүгнэж эрх үүргийг шилжүүлэн авах, дуусгавар болгох, баримт бичгийг хүлээлцэх үүрэг бүхий Ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Хэрэгжилтийн тухай мэдээлэл байхгүй. | "Хэрэгжээгүй" – 0 % | |
| | 40 | **Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай**<br>2017-02-01, № 42<br>2. Ажлын хэсгийн тайлан, үр дүнг 2017 оны 2 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Хэрэгжилтийн тухай мэдээлэл байхгүй. | "Хэрэгжээгүй" – 0 % | |
| 20 | 41 | **"Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай**<br>2018-03-27, № 81<br>1. "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Тогтоолын дагуу 1562 айлын орон сууцны дуусаагүй барилгыг "ТОСК" ТӨҮГ-ын балансаас Монгол Улсын Хөгжлийн банканд шилжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 29 дүгээр тогтоол гарч, улмаар Барилга, хот байгуулалтын яам, Монгол Улсын Хөгжлийн банк, "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ харилцан | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газрын балансад бүртгэлтэй хавсралтад заасан орон сууцны дуусаагүй барилгыг хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрт нь тооцон Хөгжлийн банкинд шилжүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт тус тус даалгасугай. | тохиролцож, 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр №2/53/102, 2018/04-02 дугаартай "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулсан.<br>2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн №3/94 тоот "Дуусаагүй барилга хүлээлцэх акт"-аар барилгын үнийн дүнг 35,477,278,512 төгрөг буюу зөвхөн барилга санхүүжүүлсэн дүнгээр актаар хүлээлгэж өгсөн бол Барилга, хот байгуулалтын яам, Хөгжлийн банкны ТУЗ-ийн хуралд оруулж баталгаажуулснаар нийт өртгөөр нь шилжүүлэхээр болсон.<br>Барилга, хот байгуулалтын яам, Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ийн хуралд танилцуулсны дараа 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр №3/94А тоот "Барилга, байгууламж хүлээлцэх" актаар барилгын өртгийг 46,318,281,080 төгрөг хүртэл нэмэгдүүлж Монгол Улсын Хөгжлийн банканд шилжүүлж, энэ тогтоолын биелэлт бүрэн хангагдсан болно. | | |
| 21 | 42 | **Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2018-08-01, № 232<br>2. "Нарийнсухайтын төмөр зам" ХХК-тай хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой "Шивээхүрэн төмөр зам" ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>ТӨБЗГ-аас 2018 онд өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу "Монголын төмөр зам" ТӨХК нь "Шивээхүрэн төмөр зам" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээний гол нөхцөл, гэрээний төслийг тухайн үед боловсруулан "Нарийнсухайтын төмөр зам" ХХК-д хүргүүлж байсан. Төмөр замын царигийн асуудлыг УИХ-аас эцэслэн шийдвэрлэсний дараа уг асуудлаар санал солилцохоор болсон. Гэрээний нөхцлүүд дээр хэлцэл хийх боломжит хувилбаруудыг боловсруулан ажилласан.<br>Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар "Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийг 1435 мм-ээр тогтоох тухай" УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. УИХ-ын ЭЗБХ-ны 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийн асуудлыг хэлэлцэж, "УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр дэмжиж шийдвэр гаргасан. 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн УИХ-ын чуулганаар УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, Монгол Улсын төмөр замын бүх чиглэл 1520 мм-ийн царигаар баригдах болсноор хамтарсан компани байгуулагдаагүй. | "Хэрэгжилт хангалтгүй" – 30% | |
| 22 | 43 | **Үл хөдлөх хөрөнгө нэлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай** | **ТӨБЗГ – ТӨУЗХ** | "Хэрэгжилтийг тооцох хугацаа | Засгийн газрын 2020 оны |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2018-09-12, № 286<br>1. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 5986 м.кв талбай бүхий 5 барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн "Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх тухай" 167 дугаар тогтоолын 2 дахь заалтаар энэхүү "Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай" тогтоолыг хүчингүй болгосон. | болоогүй" – ХБ. | 167 дугаар тогтоолоор хүчингүй болсон. |
| 23 | 44 | **"Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай**<br>2018-10-31, № 328<br>3. "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, компанийн өр, авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд **Х.**Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Хөгжлийн банкны зээлээр барьж буй байруудыг "Түрээсийн орон сууц" хөтөлбөрт хамруулах тухай Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан 82.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий орон сууцыг Түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн.<br>Барилга, хот байгуулалтын яам болон "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн хооронд 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан №2019/194, 219/4-15 тоот гэрээний дагуу 5.0 тэрбум төгрөгийг Монгол Улсын Хөгжлийн банкинд 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр шилжүүлж, "Буянт-Ухаа 2" хорооллын үндсэн зээлийн төлбөрт төлсөн.<br>"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн нийт өр төлбөрийг шийдвэрлэх зорилготойгоор Монгол Улсын Хөгжлийн банкнаас шүүхийн шатанд шилжүүлээд байсан нийт 45.5 сая ам доллар буюу 124,172.4 сая төгрөгийн маргаанууд шийдвэрлэгдэх шатанд байна. Үүнд:<br>1.Монгол Улсын Хөгжлийн банкны нэхэмжилсэн "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ /хуучнаар/-тай байгуулсан 3-0С-Б 2015-33 дугаартай Зээлийн гэрээг цуцалж, үндсэн зээл, зээлийн үндсэн хүүгийн төлбөрт нийт 36,212,725.75 ам.доллар буюу 98,522,514,520.62 төгрөгийг Хөгжлийн банкинд олгуулах шаардлага бүхий нэхэмжлэл,<br>2.Монгол Улсын Хөгжлийн банкны нэхэмжлэлтэй үндсэн зээл, зээлийн үндсэн хүү болон нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт нийт 9,398,540.36 ам.доллар буюу Монгол банкнаас зарласан тухайн үеийн ханшаар тооцож 25,649,932,438.09 төгрөгийг зээлдэгч "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-аас гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэл, | "Хэрэгжих шатанд" - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3.Хөгжлийн банкны зүгээс "Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн цогцолбор"-ыг худалдан авахад зориулсан зээлийн төлбөрийг шийдвэрлэж балансаас балансад шилжүүлэх арга хэмжээ авч, Засгийн газрын 2017 оны 48 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах. | | |
| 24 | 45 | **Дүрэм батлах тухай (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм)**<br><br>2019-01-23, № 33<br><br>2.Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ХЭЗХ, ЗУХ**<br><br>Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоол гарч, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсан, төрийн захиргааны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбогдуулан байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг шинэчлэх ажлыг байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ аван ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/48 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна. Хөдөлмөрийн дотоод журмыг Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д нийцүүлэн боловсруулж байна. Ажлын хэсгээс уг журмын төсөлд нийт албан хаагчдаас санал авах ажлыг зохион байгуулж, хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| 25 | 46 | **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв байгуулах тухай**<br><br>2019-04-03, № 125<br><br>2.5. Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 2016 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн хэлэлцээрийн дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв барих" төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид бүртгэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв барих" төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид бүртгэх ажил хийгдэж байна.<br><br>Эхний ээлжинд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв" нь хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.<br><br>Барилгыг улсын комисс хүлээн аваагүй байгаа тул төрийн өмчид бүртгэх ажил хүлээгдэж байна. ТӨБЗГазраас шалтгаалаагүй. | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 26 | 47 | **Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-04-17, № 149<br>3.Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй. | **ТӨБЗГ – МТА, Хэлтсүүд**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас иргэдэд шууд үзүүлдэг цахим үйлчилгээ байхгүй бөгөөд холбогдох байгууллагуудад мэдээлэл хүргүүлсэн болно. | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 27 | 48 | **Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>2019-07-24, № 304<br>2. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д зөвшөөрч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төслийн үйл ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэх зорилгоор “Тавантолгой төмөр зам” ХХК-д санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-иас төслийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж, “Монголын төмөр зам” ТӨХК-тай 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн ЭТТ-2019/351 дугаар бүхий Төслийн санхүүжилтийн урьдчилгаа төлбөр олгох гэрээг байгуулсан.<br>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авах хэрэгжүүлж байна.<br>Энэ хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компанийн зүгээс дараах санхүүжилтүүдийг хийсэн. Үүнд:<br>- Үйл ажиллагааны зардалд 15.0 тэрбум төгрөгийн шууд хөрөнгө оруулалт;<br>- Хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу урьдчилсан санхүүжилт хэлбэрээр 110.0 сая ам.долларын шууд хөрөнгө оруулалт; | “Хэрэгжиж шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | - Нүүрс урьдчилан борлуулах гэрээний дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК-д 2021 оны 4 сарын 30-ны өдрийн байдлаар 1,281,586,373,011 төгрөгийн санхүүжилтийг хийгээд байна.<br>Засгийн газрын тогтоолоор өгсөн чиглэлийн дагуу ажил дуусах хүртэлх бүх хөрөнгө оруулалтыг нүүрс урьдчилан борлуулах гэрээгээр бүрэн шийдвэрлэсэн. | | |
| 28 | 49 | **Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай**<br>2020-01-08, № 9<br>1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон явуулж, дүнг 2020 оны IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогод ашиглах төрийн өмчийн бүртгэлийн болон захиргааны статистикийн маягтуудыг шинэчлэн батлуулах асуудлыг боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалаар ТӨБЗГ-т маягтыг баталж, мөрдүүлэх тухай зөвшөөрөл авсан. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/70 дугаар тушаалаар өмнө мөрдөж байсан маягтуудыг хүчингүй болгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн. Шинэчлэн боловсруулсан маягтуудыг батлуулахаар ТӨБЗГ-ын хуралдаанд оруулахаар бэлтгэл хангаад байна.<br>Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тооллогын ажлыг хойшлуулах санал бүхий Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт бэлтгэн ТӨБЗГ-ын 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А-1/983 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 42 дугаар тогтоолоор энэхүү тогтоолд өөрчлөлт оруулж, улсын үзлэг, тооллогыг 2021 онд зохион байгуулахаар шийдвэрлэсэн.<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт улсын үзлэг тооллогыг 2021 онд зохион байгуулах асуудлыг тусгасан боловч 2021 оны төсөвт зардлын асуудал тусгагдан батлагдаагүй.<br>Засгийн газрын тогтоолд орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан удирдамж, Үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, асуулгын дагуу зохион байгуулж, дүнг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ТӨБЗГ-т хүргүүлэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасны дагуу 2021 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган Газар зохион байгуулалт, барилга, хот байгуулалтын газар, хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагатай уялдаатай ажиллах, улсын үзлэг, тооллогын | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажлын бэлтгэл хангах зөвлөмж хүргүүлэх тухай албан бичгийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлээд байна.<br><br>Нөхцөл байдлаас шалтгаалан хойшлуулах шийвэрийн төсөл Засгийн газарт хүргүүлсэн. | | |
| 29 | 50 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-01-08, №10<br><br>6. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олгосон газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, төрийн өмчийн бүртгэлд тусгаж байхыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан), Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>Сангийн яамнаас 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 7/1403 дугаартай албан бичгээр үнэлгээний аргачлалыг дахин боловсруулах чиглэлийг ирүүлсэн. Аргачлалыг дахин боловсруулах зардал, хугацаа байхгүй тул 2018 оны дахин үнэлгээний аргачлалыг хэрэглэх саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А-1/725 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлэв.<br><br>Сангийн сайдын 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 7/4446 дугаар албан бичгээр газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээнд Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг ашиглах чиглэл ирүүлсэн тул 2018 оноос 2020 онд шинээр олж авсан газар эзэмших, ашиглах эрхийг дээр дурдсан аргачлалын дагуу нөхөн үнэлж, нягтлан шалгалтын үнэлгээчнээр баталгаажуулан, дүнг 2020 оны санхүүгийн тайланд тусгах чиглэлийг ТӨБЗГ-аас нийслэл, 21 аймгийн Засаг дарга нар, Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газарт тус тус хүргүүлсэн. Үнэлгээ хийж бүртгэлд тусгах ажил тухай бүр хийгдэж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | Бүрэн хийгдсэн тул хяналтаас хасах саналтай |
| | 51 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-01-08, № 10<br><br>10. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн програм хангамжийг боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад мэдээллийн сантай холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ, МТА**<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх асуудлын хувилбарыг судалж байна.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн програм хангамжийг боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад мэдээллийн сантай холбох арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/31 тоот тушаалаар 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. | "Хэрэгжилт хангалтгүй" – 30% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2021 оны төсвийн тодотголд тусгах хүсэлтийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд уг асуудлыг тусгахаар санал боловсруулж, холбогдох материалын хамт ЗГХЭГ-т хүргүүлэв. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгуулах саналаа мөн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. | | |
| 30 | 52 | **Орон сууц хувьчлах тухай**<br>2020-02-12, № 56<br>2. Албан тушаалын орон сууцуудыг ашиглаж байгаа оршин суугчдад хөнгөлөлттэй үнээр худалдан шилжүүлэх болон хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Энэ тогтоолоор Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын эзэмшилд байгаа албан тушаалын 597 орон сууцыг оршин суугчдад нь хувьчлах болон хөнгөлөлттэй үнээр худалдан шилжүүлэхээр шийдвэрлэсний дагуу Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/76, А/188 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Уг ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажилласан бөгөөд тус ажлын хэсгээс 35 айлын орон сууцыг оршин суугчдад нь хувьчлахаар, 562 айлын орон сууцыг хөнгөлөлттэй үнэ тогтоон, худалдан шилжүүлэхээр тус тус шийдвэрлэсэн. Ажлын хэсгийн гаргасан дүгнэлт, саналын дагуу гэрээний үүргээ биелүүлсэн 597 айлын орон сууцыг одоо эзэмшиж буй оршин суугчдад хувьчлахаар “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг Батлан хамгаалах яамнаас олгосон. Холбогдох материалыг хянан үзэж, өмчлөх асуудлыг шийдвэрлэх хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А-1/552 дугаар албан бичгээр Нийслэлийн орон сууц хувьчлах товчоонд хүргүүлэв. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 31 | 53 | **Төлөвлөгөө батлах тухай**<br>2020-02-19, № 66<br>1.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.<br>2.Төлөвлөгөөнд тусгагдсан хуулийг тогтоосон хуваарийн дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br>1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн холбогдох баримт материалын хамт боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2021 оны ХЭГ/1405 тоот албан бичгээр ирүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалд тусгах саналыг боловсруулж, 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А-1/939 тоот албан бичгээр хүргүүлсэн. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 32 | 54 | **Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай** | | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2020-03-25, № 106<br><br>1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br><br>Тогтоолын заалтаар өгсөн үүрэг даалгавар, улсын үзлэгийн комиссын дүгнэлтийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж байна. Улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээг судлан тодорхойлох, холбогдох албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэх ажлыг нарийвчлан тусгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br><br>Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоол гарч, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсан, төрийн захиргааны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбогдуулан байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг шинэчлэх ажлыг байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ аван ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам", "Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн заавар", "Албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.<br><br>2021 оны эхний хагас жилд төрийн захиргааны 20 албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан Төрийн албаны зөвлөлд хянуулах арга хэмжээг авч ажиллав. Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 06, 07, 08 дугаар тогтоолоор батлах зөвшөөрөл өгснийг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А/07, А/08, А/09 дүгээр тушаалаар тэдгээр албан тушаалын тодорхойлолтыг баталж, мөрдүүлэв. | | |
| | 55 | **Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-03-25, № 106<br><br>2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан | **ТӨБЗГ – ЗУХ**<br><br>Улсын үзлэгийн мөрөөр хэрэгжүүлэх ажлыг байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ажиллаж байна. Зарим хөрөнгө шаардагдах ажлыг хэрэгжүүлэхэд төсөв, хөрөнгө дутагдалтай байна, 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021 оны төсвийн төсөлд шаардлагатай хөрөнгийг тусгах талаар судалгаа, тооцоо хийж, тусгах арга хэмжээ авсан боловч холбогдох байгууллагаас батлаагүй байна. Байгууллагын 2021 оны батлагдсан төсвийн хүрээнд холбогдох ажлыг хэрэгжүүлэн | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | ажиллаж байна. 2022 оны төсвийн төсөлд шаардлагатай хөрөнгийг тусгах арга хэмжээ авахаар бэлтгэж байна. | | |
| 33 | 56 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-04-15, № 127<br><br>2.1. Онцгой дэглэмийн хугацаанд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг бүрэн хангаж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд даалгасугай: 2.1. “Эрдэнэт үйлдвэр” ХХК (хуучин нэрээр), “Монголросцветмет” ХХК (хуучин нэрээр)-ийн 2016-2019 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг эрчимжүүлж, хууль зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй, компанийн эрх ашигт нийцээгүй гэрээ хэлцэлтэй холбоотойгоор хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, "Монголросцветмет" ТӨҮГ-ын Захирал Б.Мөнхбат нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2016-2019 оны үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br><br>Мөн “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Кью Эс Си” ХХК, “Цемент шохой” ХК, "Монголиан коппер корпорэйшн" ХХК, "Цэц мөнх" ХХК, "Рэс" ХХК, "Гурван уул" ХХК, "Тайтлан Ресорсиз Монголиа" ХХК зэрэг хуулийн этгээдтэй холбоотой зарим асуудлыг шалгуулах нь зүйтэй гэж үзэж хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн.<br><br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон “Монголросцветмет” ТӨҮГ-т тогтоосон онцгой дэглэмийн хугацаа дуусгавар болсон боловч УИХ-ын 2017 оны 23 дугаар тогтоолын 3, 4 дүгээр заалтууд бүрэн хэрэгжээгүй, хууль хяналтын байгууллагад болон шүүхэд шилжүүлсэн хэргүүд эцэслэн шийдвэрлэгдээгүйгээс Засгийн газрын энэ тогтоолоор эдгээр үйлдвэрийн газарт тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, үйлдвэрлэлийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг цаашид хангах зайлшгүй шаардлагыг харгалзан ... 6 сарын хугацаагаар дахин онцгой дэглэм тогтоосон. Тогтоолын хэрэгжилтийг хуулийн хүрээнд зохион байгуулж ажилласан. Онцгой дэглэмийн үеийн сар, улирлын мэдээллийг ЗГХЭГ-т мэдээлж, холбогдох материалыг тухайн үйлдвэрийн газраас болон ТӨБЗГ-ын зүгээс хүргүүлж ажилласан.<br><br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-т онцгой дэглэм тогтоосон хугацааны үйл ажиллагааны үр дүнг Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, 56 дугаар тэмдэглэлээр сайшаасан. Уг тэмдэглэлд, “2020 оны эхний 3 улирлын байдлаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь борлуулалтын орлогыг 98.0 тэрбум төгрөгөөр өсгөж, цэвэр ашгийг 318.7 тэрбум төгрөгт хүргэн, улс, орон нутгийн төсөвт 642.4 тэрбум төгрөгийн татварыг, “Монголросцветмет” ТӨҮГ нь борлуулалтын орлогыг 28.7 тэрбум төгрөгөөр өсгөж, цэвэр ашгийг 24.4 тэрбум төгрөгт хүргэн, улс, орон нутгийн төсөвт 30.8 тэрбум төгрөгийн татварыг тус тус төвлөрүүлэн, хөрөнгө оруулалтыг жил тутам эрс нэмэгдүүлж ажилласан” гэж тэмдэглэсэн. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 57 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-04-15, № 127<br>2.2. Лондонгийн олон улсын арбитрын шүүхийн шийдвэрээр “Эрдэнэт үйлдвэр” **ХХК** (хуучин нэрээр)-иас Стандарт банкинд төлсөн төлбөрийг буруутай этгээдээр буцаан шуурхай төлүүлэх талаар холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан) “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Стандарт банктай холбоотой хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх талаар Засгийн газраас чиглэл, удирдамж өгч ажилласны дүнд 2019 оны 04 дүгээр сарын эхээр 40.0 сая ам.долларыг Стандарт банкинд төлж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын гадаад дахь өр төлбөрийн асуудал хаагдсан.<br>Дотоодод энэ асуудал хууль, хяналтын байгууллагуудаар шалгагдаж, шүүхийн шатанд хянагдан дараах шийдвэр гарсан үр дүнтэй байна. Үүнд: Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2020 оны 10 дугаар сарын 05-22-ны өдрүүдэд хуралдаж, яллагдагч Ш.Батхүүд холбогдох хуулийн зүйл, заалтын дагуу нийт 8 жилийн хорих ялыг хаалттай хорих ангид эдлүүлэхээр шийдвэрлэж, уг өдрөөс эхлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна. Мөн яллагдагчийн битүүмжлэгдсэн эд хөрөнгүүдийг хохирол төлбөрт тооцон төлүүлэхээр шийдвэрлэсэн. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас хохирол, хор уршиг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд нийт 139,261,801,236 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлага гаргаснаас хэрэгтэн Ш.Батхүүгээс 137,958,871,267 төгрөгийн хохирол, хор уршгийг гаргуулахаар шүүхээс шийдвэрлэсэн. Уг шийдвэрийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хянан үзээд хангаж шийдвэрлэсэн байна.<br>2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр болсон нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хуралдаанаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд зарим нэг өөрчлөлтийг оруулж, зүйлчилснээр Ш.Батхүүд **нийт 7** жилийн хорих ялыг нээлттэй хорих ангид эдлүүлэх, гадаад дахь эд хөрөнгийг анхан шатны шүүх улсын орлого болгохоор шийдвэрлэснийг давж заалдах шатны шүүх хохирол төлбөрт тооцон төлүүлэхээр шийдвэрлэсэн. Ш.Батхүү нарын гомдлыг Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхим 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хянан хэлэлцэх товыг гаргаад байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 58 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-04-15, № 127<br>2.3. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ аван ажилласан.<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах, 2020 оны | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төслийг үе шаттайгаар шуурхай хэрэгжүүлэхийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах, 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахал болон дэлхийн зах зээл дээрх металлын үнийн уналтаас үүсээд байгаа хүндрэлийг даван туулах хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж ажиллахыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, "Монголросцветмет" ТӨҮГ-ын Захирал Б.Мөнхбат нарт; | эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар бүхий л боломжоо дайчлан ажиллаж байна. Коронавирусын цар тахлын улмаас 2020 онд дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын гаралтай түүхий эдийн үнэ хэлбэлзэл ихтэй байлаа. 2020 оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөснөөс 501 ам. доллароор бага байсан бол сүүлийн хагас жилд 6,800 орчим ам. доллар хүртэл өссөнөөр 2020 оны дундаж үнэ 6,168.6 ам. доллар болж, төлөвлөснөөс 177.6 ам. доллар, өнгөрсөн оны мөн үеэс 163.5 ам. доллароор тус тус өссөн.<br><br>2020 онд 2,203.8 тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөөг 115.8 хувиар, 1,774.3 тэрбум төгрөгийн зардал гарган, 263.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, ашгийн төлөвлөгөөг 36.7 хувиар давуулан биелүүлсэн.<br><br>2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахал болон дэлхийн зах зээл дээрх металлын үнийн уналтаас үүсээд байгаа хүндрэлийг даван туулах хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд "Монголросцветмет" ТӨҮГ 2020 оны үндсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлж, 48.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. | | |
| 34 | 59 | **Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай**<br><br>2020-04-22, № 144<br><br>1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Засгийн газрын IX байранд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Засгийн газрын нийтлэг үйлчилгээний газраас тус байрыг дулааны тоолуураар хангасан байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| 35 | 60 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай**<br><br>2020-09-23, № 117 | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар "Эрдэнэс-Тавантолгой" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг үндэслэн "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 3."Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн хувьцааг хаалттай хүрээнд нэрлэсэн үнээр худалдах замаар нийт хувьцааны 66 хувийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д, 34 хувийг "Монголын төмөр зам" ТӨХК-д тус тус эзэмшүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т, цаашид "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг "Монголын төмөр зам" ТӨХК-д эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу үе шаттай шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур), "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Баярсайхан)-д тус тус даалгасугай. | дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийг үүсгэн байгуулах тогтоолыг баталж, компанийг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. "Зүүнбаян төмөр зам" ХХК нь 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн гүйцэтгэх захирлаар Д.Банзрагчийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс томилсон. Одоогийн байдлаар "Зүүнбаян төмөр зам" ХХК нь 18 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. | | |
| | 61 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай**<br>2020-09-23, № 117<br>4."Монголын төмөр зам" ТӨХК-иас Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах, хөндлөнгийн аудит хийлгэхэд шаардагдах зардлыг "Монголын төмөр зам" ТӨХК-ийн 2020 оны зорилтот түвшний үзүүлэлтийг тодотгох замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур)-д тус тус зөвшөөрсүгэй. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Одоогоор аудит хийгдээгүй байгаа болно. Үндэсний аудитын газарт 2 удаагийн албан бичгээр аудит хийлгэх хүсэлтээ илгээсэн боловч 2020 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй тул 2020 онд хийх боломжгүй тухай хариуг хүлээн авсан болно. Одоогийн байдлаар хөндлөнгийн аудит хийгдээгүй байна. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| | 62 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай**<br>2020-09-23, № 117 | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А/35 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж, "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасны дагуу "Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ"- | "Хэрэгжилт хангалтгүй" – 30 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 7.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан "Монголын төмөр зам" ТӨХК болон "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хооронд байгуулсан "Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ", "Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ"-г хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээ"-нд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур), "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Баярсайхан)-д даалгасугай. | ний төсөл боловсруулах болон "Монголын төмөр зам" ТӨХК болон "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хооронд байгуулсан "Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ", Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээ"-нд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан. Эдгээр гэрээний төслийг "Монголын төмөр зам" ТӨХК болон "Зүүнбаян төмөр зам" ХХК-д хүргүүлсэн бөгөөд саналыг үндэслэн холбогдох гэрээнүүдийг баталгаажуулахаар ажиллаж байна. | | |
| 36 | 63 | **Тавантолгой дулааны цахилгаан станц төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-11-11, № 175<br><br>2. "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийн төрийн эзэмшлийн 70 хувьд ногдох төлөөллийг хэрэгжүүлэхдээ Эрчим хүчний яам 70 хувиас доошгүй хувийн төлөөлөлтэй байхаар тогтоож хэрэгжүүлэхийг Эрчим хүчний. сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Тогоолыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын ажлын хүрээнд "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийн нийт хувьцааны 51 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 19 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшихээр зохион байгуулагдаж, төлөөллийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д ногдсон 30 хувийн хувьцаа эзэмшигчийн эрхийн итгэмжлэгдсэн төлөөллийг Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам хэрэгжүүлж байна.<br><br>"Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2020 оны 10 болон 12 дугаар сард тус тус хуралдаж, компанийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай, Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүд болон хараат бус гишүүдийг томилох тухай асуудлыг хэлэлцэн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэсэн болно.<br><br>Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар компанийн гүйцэтгэх захирлыг томилж, "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.<br><br>"Тавантолгой дулааны цахилгаан станц" төслийн нийт хөрөнгө оруулалтын 70 хувь буюу 565,796,000 (таван зуун жаран таван сая долоон зуун ерэн зургаан мянга) ам.долларыг 9.4 жилийн хугацаатайгаар Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр шийдвэрлүүлэхээр холбогдох материал, зөвшөөрлыг хүргүүлсэн болно. Тавантолгой дулааны цахилгаан станц | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төслийн ТЭЗҮ, БОНҮ болон шаардлагатай бичиг баримт хийгдсэн болно.<br><br>Үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа. | | |
| 37 | 64 | **Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-12-02, № 200<br><br>1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийслэлийн гэр хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг 50 хувиар хөнгөлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Таван толгой түлш” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Батбаясгалан)-д тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээг баталсан. Энэ тогтоолд заасан сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг 50 хувиар хөнгөлөх хэмжээг үе шаттайгаар нийт 75 хувиар хөнгөлөхөөр өөрчлөлт оруулснаар хэрэгжилтийг зохион байгуулж байна. Үүнтэй холбоотойгоор “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшийг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 13-ны өдрийг хүртэл 50 хувийн хөнгөлөлттэй үнээр, 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 75 хувийн хөнгөлөлттэй үнээр борлуулж эхэлсэн. 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сайжруулсан шахмал түлшний 679 борлуулалтын цэгээр дамжуулан 135,776.8 тонн түлшийг нийслэлийн гэр хорооллын иргэдэд хөнгөлөлттэй үнээр борлуулсан байна.<br><br>2021 оны 1 дүгээр сард 112,894 тонн, 2 дугаар сард 84,746 тонн, 3 дугаар сард 83,782 тонн, нийт 378,638 тонн түлшийг хөнгөлөлттэй үнээр борлуулсан байна. Сайжруулсан шахмал түлшний үнийн зөрүү санхүүжилтийг гүйцэтгэлээр нь “Эрдэнэс тавантолгой” ХК-иас олгосон. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 38 | 65 | **Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-12-13, № 211<br><br>4. Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хэмнэлтийн горимд ажиллуулж, үр ашгийг дээшлүүлэх, халдвар, хамгааллын онцгой дэглэмийг чанд баримтлах, халдвараас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А-1/354 дүгээр албан бичгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 105 компани, үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захирал нарт Монгол Улсын Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу компани, үйлдвэрийн газруудыг хэмнэлтийн горимд шилжүүлж, зардлыг 10 хувиар бууруулах, бүтэц, орон тоог оновчтой болгох, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, шагнал урамшуулал олгохгүй байх, мөн хэмнэлтийн болон цар тахлын үеийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг иргүүлэх талаар албан даалгаврыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Мөн төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн удирдлага, холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан цахим хурал зохион байгуулж, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж буй ажлын хүрээнд санхүүгийн сахилга батыг чангатгах, үр ашиггүй зардал, хөрөнгө худалдан авахгүй байх, ажилтан, албан хаагчдын ажиллах өдөр, цагийг оновчтой хуваарилах, шагнал урамшуулал, хандив, тусламж, хөтөлбөр, арга хэмжээнд зардал гаргахгүй байх бусад зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх талаар үүрэг даалгавар, чиглэл өгсөн. | | |
| | 66 | **Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>2020-12-13, № 211<br>5. Төрийн байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс бууруулахгүй, өөр зардалд шилжүүлэхгүйгээр цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад шууд шилжүүлж байхыг төсвийн бүх шатны захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ**<br>Төрийн байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс бууруулахгүй, цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад шууд шилжүүлэх ажлыг ТӨБЗГ болон харьяа төрийн өмчит хуулийн этгээд анхааран ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 67 | **Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>2020-12-13, № 211<br>6. “Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 200 дугаар тогтоолын 1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай: 1/ Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийслэлийн гэр хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшийг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 13-ны өдрийг хүртэл 50 хувийн хөнгөлөлттэй үнээр, 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 75 хувийн хөнгөлөлттэй үнээр борлуулж эхэлсэн. 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сайжруулсан шахмал түлшний 679 борлуулалтын цэгээр дамжуулан 135,776.8 тонн түлшийг нийслэлийн гэр хорооллын иргэдэд хөнгөлөлттэй үнээр борлуулсан байна.<br>2021 оны 1 дүгээр сард 112,894 тонн, 2 дугаар сард 84,746 тонн, 3 дугаар сард 83,782 тонн, нийт 378,638 тонн түлшийг хөнгөлөлттэй үнээр борлуулсан байна. Сайжруулсан шахмал түлшний үнийн зөрүү санхүүжилтийг гүйцэтгэлээр нь “Эрдэнэс тавантолгой” ХК-иас олгосон. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс 50, 12 дугаар сарын 14-ний өдрөөс 25, нийт 75 хувиар хөнгөлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Тавантолгой түлш" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Батбаясгалан)-д тус тус даалгасугай. | | | |
| | 68 | **Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-12-13, № 211<br><br>7. Энэ тогтоолын 1-д заасны дагуу төлбөр, хураамжийг төрөөс хариуцахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг нийгмийн хариуцлагын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын цэвэр ашгаас тооцож, санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Х.Бадамсүрэн), Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөхийг, шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг нийгмийн хариуцлагын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын цэвэр ашгаас тооцож, санхүүжүүлэх арга хэмжээний хүрээнд тус үйлдвэрийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд санхүүжилтийг урьдчилсан байдлаар 650.0 тэрбум төгрөгөөр тооцон тусгаж өгсөн. Энэхүү эх үүсвэрийн хүрээнд төлбөр тооцоог гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулах түр журмыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ерөнхий захирал Х.Бадамсүрэн нар хамтран баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br><br>Энэхүү цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, ус хангамж, ариутгах татуурга, хог хаягдлын төлбөрийн чөлөөлөлтөд улсын хэмжээнд нийт 897,427 айл өрх, 94,491 аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| 39 | 69 | **Төрийн өмчит дээд боловсролын байгууллагыг өөрчлөн байгуулах тухай**<br><br>2020-12-16, № 224<br><br>2. Дүрслэх, дизайн урлагийн сургуулийг Соёл, урлагийн их сургуулиас тусгаарлан "Дүрслэх урлагийн академи" дээд сургууль болгон өөрчилж, бие даалган зохион байгуулсугай.Соёл, | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>Дүрслэх, дизайн урлагийн сургуулийг Соёл, урлагийн их сургуулиас тусгаарлан "Дүрслэх урлагийн академи" дээд сургууль болгон өөрчлөн байгуулсан. Соёл, урлагийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Дүрслэх, дизайн урлагийн сургуулийн байр, газар эзэмших эрх болон бусад эд хөрөнгийг "Дүрслэх урлагийн академи" дээд сургуульд балансаас балансад шилжүүлэх ажлыг | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | урлагийн их сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Дүрслэх, дизайн урлагийн сургуулийн байр, бусад эд хөрөнгийг “Дүрслэх урлагийн академи” дээд сургуульд балансаас балансад шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгасугай. | зохих журмын дагуу зохион байгуулан “Дүрслэх урлагийн академи” дээд сургуулийн эхлэлтийн баланс дээр тусгасан талаар 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 01/278 дугаар албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдсэн. | | |
| 40 | 70 | **Төрийн өмчит хуулийн этгээдийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-12-23, № 237<br>4.Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн зохион байгуулсантай холбогдуулан хууль тогтоомжийн дагуу комисс томилж, “Биокомбинат” ТӨААТҮГ-ын эд хөрөнгөд тооллого хийж, хаалтын тайлан баланс гаргаж, үндсэн болон бусад эд хөрөнгийг өөрчлөн зохион байгуулагдсан компанид зохих журмын дагуу шилжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>ХХААХҮ-ийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/08 дугаар тушаалаар “Биокомбинат” ТӨҮГ-ыг “Биокомбинат” ХХК болгон өөрчлөн зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэгт ХХААХҮЯ, ТӨБЗГ-ын болон “Биокомбинат” ТӨҮГ-ын төлөөллөөс бүрдсэн бөгөөд комисс гарч “Биокомбинат” ТӨҮГ-ын эд хөрөнгөд тооллого хийн хаалтын тайлан баланс гаргаж, үндсэн болон бусад эд хөрөнгийг өөрчлөн зохион байгуулагдсан компанид зохих журмын дагуу шилжүүлэх ажлыг гүйцэтгэсэн. Мөн тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулсан бөгөөд ХХААХҮ-ийн сайдын А-1/790 дугаар албан бичгээр Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж, чиглэл өгсний дагуу тус Төлөөлөн удирдах зөвлөл хуралдаж, даргаар ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэнг томилсон шийдвэр гаргасан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 71 | **Төрийн өмчит хуулийн этгээдийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-12-23, № 237<br>5.“Биокомбинат” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлж, компанийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Биокомбинат” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг 2020 оны Засгийн газрын 237 дугаар тогтоолоор баталсан. Тус компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь ХХААХҮЯам хариуцаж байгаа болно. “Биокомбинат” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүнээс 1 гишүүн нь ТӨБЗГ-ын төлөөлөл ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 41 | 72 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2020-12-30, № 242 | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>**Ашигт** малтмал газрын тосны газрын балансаас Үндэсний Геологийн Албаны балансад шилжүүлсэн 2,280,844,356.17 | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2. Ашигт малтмал, газрын тосны газрын балансад бүртгэлтэй нийт 2,320,549,420.95 (хоёр тэрбум гурван зуун хорин сая таван зуун дөчин есөн мянга дөрвөн зуун хорин төгрөг ерэн таван мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгө, нийтийн эзэмшлийн байгууламжийг Үндэсний геологийн албаны балансад шилжүүлсүгэй. 2. Энэ тогтоолд заасан үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | төгрөгийн өртөг бүхий барилга, 39,705,064.78 төгрөгийн өртөг бүхий нийтийн эзэмшлийн байгууламж, нийт 13 нэрийн 2,320,549,420.95 төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгуулах арга хэмжээ авсан бөгөөд энэ талаар Үндэсний геологийн албанаас 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/165 дугаар албан бичгээр мэдээлэл ирүүлсэн байна. | | |
| 42 | 73 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br><br>2020-12-30, № 243<br><br>3. Шинжлэх ухааны академийн балансад бүртгэлтэй Нийслэлийн Баянзүрх дүүргийн 13 дугаар хороонд байрлах 9,109,075.50 (есөн сая нэг зуун есөн мянга далан таван төгрөг тавин мөнгө) төгрөгийн үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан бетон гараашийг Хими, химийн технологийн хүрээлэнгийн балансад шилжүүлсүгэй.<br><br>3. Энэ тогтоолын 1, 2 дахь заалтад заасан үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>Шинжлэх ухааны академи нь 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/142 дугаар албан бичгээр балансаас балансад шилжүүлсэн нийт 183,757,440.33 төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг данс бүртгэлээс хассан талаар тогтоолын биелэлт ирүүлсэн. Одон орон, геофизикийн хүрээлэн шилжүүлэн авсан 174,648,364.83 (нэг зуун далан дөрвөн сая зургаан зуун дөчин найман мянга гурван зуун жаран дөрвөн төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг данс бүртгэлд тусгасан талаар 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 184 дүгээр албан бичгээр, Хими, хими технологийн хүрээлэн Шинжлэх ухааны академийн балансад бүртгэлтэй Нийслэлийн Баянзүрх дүүргийн 13 дугаар хороонд байрлах 9,109,075.50 (есөн сая нэг зуун есөн мянга далан таван төгрөг тавин мөнгө) төгрөгийн үнэ бүхий гражийг зохих журмын дагуу бүртгэлдээ тусгасан талаар 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/178 дугаар албан бичгээр тус тус Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдэж, тогтоолын хэрэгжилтийг мэдээлэв. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| 43 | 74 | **Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-12-30, № 253<br><br>3. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг, эрхлэх асуудалд хамаарахгүй байна.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ Улсын төсвийн хөрөнгө, оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдаагүй болно. | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | захирагчийн багцын дүнд хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх; 1.2. Монгол Улсад короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тохиолдол бүртгэгдэж бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс шалтгаалан эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж байгаа 2020 онд хэрэгжиж дуусах боловч батлагдсан санхүүжилтийг бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн, мөн бусад салбарын зайлшгүй шаардлагатай болон Засгийн газрын 2019 оны 280 дугаар тогтоолын хүрээнд хийгдэж байгаа бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний 2020 оны үлдэгдэл санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах. 2. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төслүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. 3.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай. | | | |
| 44 | 75 | **Шивээхүрэн боомтод чингэлэгт тээврийн гарц нээх тухай**<br>2020-12-30, № 254<br>2. Шивээхүрэн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалтаар уг боомтод нүүрс тээвэрлэлтийн чингэлэгтэй автомашины хяналтын нэмэлт гарцыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах хуулийн этгээдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд зөвшөөрсүгэй. 2. Энэ тогтоолын 1-д заасны дагуу барьсан нэмэлт гарцыг төрийн өмчид бүртгэн Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Шивээхүрэн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалтаар уг боомтод нүүрс тээвэрлэлтийн чингэлэгтэй автомашины хяналтын нэмэлт гарцыг барьж байгуулсны дараа Төрийн өмчид бүртгэн авах ажиллагаа хийгдэх тул хүлээгдэж байна. | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | | | |
| 45 | 76 | **Жагсаалт батлах тухай**<br><br>2021-01-15, № 15<br><br>3. "Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралт, "Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт, "Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтад заасан бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааг урьд нь байгуулсан ерөнхий гэрээний хүрээнд зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ**<br><br>Энэ тогтоолоор батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцан зохион байгуулах худалдан авах ажиллагаа тусгагдаагүй болно. | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | ТӨБЗГ-т хамаарахгүй байна.<br><br>Тогтоол ТӨБЗГ-т албан ёсоор бүртгэгдээгүй болно.<br><br>Легалинфо эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд энэ дугаар бүхий тогтоол байхгүй байна. |
| 46 | 77 | **Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2021-02-17, № 43<br><br>1. Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад улс, орон нутгийн төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус даалгасугай: 1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дунд 10- | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ЗУХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А-1/354 дүгээр албан бичгээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 105 компани, үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захирал нарт Монгол Улсын Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу компани, үйлдвэрийн газруудыг хэмнэлтийн горимд шилжүүлж, зардлыг 10 хувиар бууруулах, бүтэц, орон тоог оновчтой болгох, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, шагнал урамшуулал олгохгүй байх, мөн хэмнэлтийн болон цар тахлын үеийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг ирүүлэх талаар албан даалгаврыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br><br>Мөн төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн удирдлага, холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан цахим хурал зохион байгуулж, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж буй ажлын хүрээнд санхүүгийн сахилга батыг чангатгах, үр ашиггүй зардал, хөрөнгө худалдан авахгүй байх, ажилтан, албан хаагчдын ажиллах өдөр, цагийг оновчтой | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах; 1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх; 1.3. төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх; 1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх; 1.5. салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх; 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх; 1.7. хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас | хуваарилах, шагнал урамшуулал, хандив, тусламж, хөтөлбөр, арга хэмжээнд зардал гаргахгүй байх бусад зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх талаар үүрэг даалгавар, чиглэл өгсөн.<br><br>ТӨБЗГ нь төсвийн хуваарийн дагуу сар бүрийн зардлын санхүүжилтийн эрхийг Сангийн яамнаас авч, батлагдсан төсвийн хуваарилалтын дагуу төсвийн зарцуулалтыг хийж ажиллав.<br><br>Хурал, семинар, сургалт, сурталчилгааны ажлууд цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх; 1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; 1.9. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах. | | | |
| 47 | 78 | **“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” батлах тухай**<br><br>2021-03-10, № 58<br><br>3. Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Тогтоолыг харьяа төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хүргүүлэх, олон нийтэд сурталчлан таниулахад анхааран ажилласан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 48 | 79 | **Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2021-03-24, № 70<br><br>1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай: 1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбогдуулан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах; 1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүжилтийн | **ТӨБЗГ – ТӨБАХ, ЗУХ**<br><br>1.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хүрээнд бий болж буй хөрөнгийг тухай бүр төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэж байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар 207 байгууллагын нийт 1.2 их наяд төгрөгийн хөрөнгийг төрийн өмчид бүртгэх, эзэнжүүлж, эзэмшүүлэх шийдвэрийг гарган хэрэгжүүллээ. Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх асуудлыг аймаг, нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрууд хариуцан хийж байгаа.<br><br>Бусад заалтын тухайд, ТӨБЗГ-т улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ байхгүй болно. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шуурхай, нээлттэй, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан хангах, төсвийн тухайн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой анхаарах; "1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2021 оны 7 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулж, гэрээ байгуулсан байхаар тооцож ажиллах; 1.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлд баригдах барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхэд орон нутгаас олгодог зөвшөөрлийг зохих журмын дагуу шуурхай олгоход дэмжлэг үзүүлж ажиллах; 1.5. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар, үр дүнд тавих хяналтыг бүх шатанд дээшлүүлж, хөрөнгийг бүртгэж, баталгаажуулахад онцгой анхаарч ажиллах; 1.6. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийн гэрээний үүргийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжид холбогдох гэрээ, хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах. | | | |
| 49 | 80 | **Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br>2021-03-24, № 74<br>2. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбоотой санхүүжилтийг нийгмийн хариуцлагын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын цэвэр ашгаас тооцож санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Х.Бадамсүрэн)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбоотой өргөн хэрэглээний АИ-92 авто бинзений хангамжийг тогтвортой хангах ажлын хүрээнд 30.000 тонноор нэмэгдүүлэх зорилгоор шаардагдах санхүүжилтийг нийгмийн хариуцлагын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын цэвэр ашгаас тооцож санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн ба тус үйлдвэрийн газар нь 2021 онд улсын төсөвт ногдол ашгийн төлбөрт 200.0 тэрбум төгрөг төвлөрүүлнэ. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас "Засгийн газрын 2021 оны 74 дүгээр тогтоолын дагуу төлбөр тооцоо гүйцэтгэх түр журам"-ыг боловсруулан 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Уг журмын төсөлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам саналаа ирүүлснийг тусгаан "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас эцсийн байдлаар баталгаажуулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Сангийн яаманд тус тус хүргүүлээд байна. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| 50 | 81 | **Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2021-04-07, № 89<br>3. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв (салбар төмөр зам, ачих байгууламж)-ийг | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2021 оны хөрөнгө оруулалтын төсөвт Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн бүтээн байгуулалтад шаардагдах 217.5 тэрбум төгрөг батлагдсан. | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжүүлэхээр тооцож, тус компанийн хөрөнгөд бүртгүүлэх арга хэмжээг авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай. | "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 20 дугаар тогтоолд заасны дагуу Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн бүтээн байгуулалтад зарцуулахаар төсөвлөсөн 217.5 тэрбум төгрөгийг холбогдох гэрээний дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК-д үе шаттай шилжүүлэхээр ажиллаж байна. | | |
| 51 | 82 | **Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын иргэдэд мөнгөн дэмжлэг олгох тухай**<br>2021-04-08, № 93<br>5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт тус тус үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ**<br>Энэ тогтоолыг болон Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй, хэмнэлтийн горимоор, төсвийн сахилга хариуцлагыг чанд баримтлан ажиллахад анхаарч байна.<br>ТӨБЗГ нь төсвийн хуваарийн дагуу сар бүрийн зардлын санхүүжилтийн эрхийг Сангийн яамнаас авч, батлагдсан төсвийн хуваарилалтын дагуу төсвийн зарцуулалтыг хийж ажиллав.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "Байгууллагын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангаж, ажил эрчимжүүлэх тухай" А/80 дугаар тушаалаар өгсөн үүрэг, чиглэлийг байгууллагын зохион байгуулалтын нэгж, албан хаагчид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн дагуу албан хаагчдыг тусгай горимоор ажиллуулах арга хэмжээ авч, ээлжээр хуваарийн дагуу цөөн бүрэлдэхүүнээр ажиллуулж байна. Хуваарийн дагуу албан хаагчид гэрээсээ цахим хэлбэрээр ажиллах боломжийг бүрдүүлэн байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн байдлыг хангаж байгаа болно.<br>Хурал, семинар, сургалт, сурталчилгааны ажлууд цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байна. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| 52 | 83 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2021-04-28, № 108 | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Засгийн газрын 2021 оны 108 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 1,032,158,613.18 (нэг тэрбум гучин хоёр | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 1,032,158,613.18 (нэг тэрбум гучин хоёр сая нэг зуун тавин найман мянга зургаан зуун арван гурван төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Усны газарт балансаас балансад шилжүүлсүгэй. 2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | сая нэг зуун тавин найман мянга зургаан зуун арван гурван төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Усны газарт шилжүүлэн хүлээлгэж өгөх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж хүлээлцэв. Усны газар нь хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан балансад тусгасан талаар 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/447 дугаартай албан бичгээр мэдээлсэн байна. | | |
| 53 | 84 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2021-05-05, № 120<br>2. "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 4,154,450,800.91 (дөрвөн тэрбум нэг зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун тавин мянга найман зуун төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга, байгууламжийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй. 2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгө шилжүүлэн хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих хүрээнд хөрөнгө хүлээлцсэн акт, бүртгэлээс хассан, бүртгэлд тусгасан тайланг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх талаар 2021 оны 05 дугаар сарын 17-ны А-5/778 дугаар албан бичгээр "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид тус тус хүргүүлэв. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| 54 | 85 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2021-05-05, № 126<br>1. Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдлага, эд хөрөнгийн талаарх бүрэн эрхийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Цагдаагийн ерөнхий газрын "Цагаан шонхор" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдлага, эд хөрөнгийн талаарх бүрэн эрхийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд Засгийн газрын шийдвэрийн хүрээнд шилжүүлж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажилласан. Хүлээлгэн өгөх ажлыг дуусгасан. | "Бүрэн хэрэгжсэн" - 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шилжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | | | |
| 55 | 86 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай**<br>2021-05-05, № 129<br>2. Энэ тогтоолын 1-д заасан үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааны хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр”, “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр” болон “Засвар, механикийн заводын өргөтгөл”-ийг тус тус “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд “SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг тусгасан.<br>Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүд исэлдсэн болон ядуу агуулгатай хүдрийг SX/EW технологиор боловсруулан жилд 10,000 тн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ болон нарийвчилсан инженерийн зураг төслийн суурь судалгаа, үндэслэл, техникийн даалгавар зэрэг баримт бичгийг боловсруулж, төслийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах тендерийг 2021 оны 5 дугаар сард 2 удаа зарласан боловч тендер амжилтгүй болсон. Иймээс тендерийг 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдөр дахин зарлаад байна. | “Хэрэгжилт хангалтгүй” - 30% | |
| | 87 | **Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай**<br>2021-05-05, № 129<br>3. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газартай Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.4-т заасны дагуу гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон), хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг хуульд заасан журмын дагуу төрийн өмчид бүртгэж авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/99 дүгээр тушаалаар ҮТП-ын ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан төрийн байгууллагууд хоорондын ажлын уялдаа холбоог хангах, паркийн дэд бүтцийн төлөвлөлт болон техник, эдийн засгийн үндэслэлд заагдсан үйлдвэрүүдийг барьж байгуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.<br>Ажлын хэсэг 2021 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т ажиллаж, ҮТП-ын талбайн нөхцөл байдал, дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн байдал, хүчин чадлыг өргөтгөх боломжийг тодорхойлох, паркийн ТЭЗҮ-д тусгагдсан нэгж үйлдвэрүүдийн эрчим хүч, усан хангамж, төмөр зам, авто зам зэрэг дэд бүтцийг барихад шаардлагатай арга хэмжээний талаар санал солилцож, паркийн дэд бүтэц, нэгжүүдийн бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөөний талаарх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэлтэй танилцсан болно. | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ЗГТогтоол: 38 шийдвэрийн 50 заалт | 100% - 17 заалт; 70% - 21 заалт; 30% - 4 заалт; 0% - 2 заалт; ХБ/ҮБ – 6 заалт; Хэрэгжилтийн хувь – 74.8%. | | |
| Долоо. Ерөнхий сайдын захирамж | | | | | |
| 56 | 88 | **Төлөвлөгөө батлах тухай**<br>2020-07-01, № 99<br>2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)"-г хавсралт ёсоор батал сугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр байгууллагын нийт албан хаагчдад холбогдох хууль тогтоомж, төлөвлөгөөг танилцуулж, ойлголт мэдээлэл өгсөн. Хүний нөөцийн мэдээлэл, тайланг жендерийн мэдрэмжтэй гаргаж байх талаар анхааран ажиллаж байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах асуудлыг тусгасан бөгөөд уг хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээг жендерт суурилсан судалгаа, дүгнэлтэд тулгуурлан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| 57 | 89 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br>2020-09-07, № 43<br>4. Төрийн өмчит хуулийн этгээд (Улсын төсөвт үйлдвэрийн газар, Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Төрийн өмчит компани, Төрийн өмчийн оролцоотой компани)-ийн эрх зүйн байдал, зааг ялгаа, чиг үүргийг судалж, тэдгээрийн үйл ажиллагаанд цогц байдлаар дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг 2020 оны 10 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 43 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгээс төрийн өмчит хуулийн этгээд (улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төрийн өмчит компани, төрийн өмчийн оролцоотой компани)-ийн эрх зүйн байдал, зааг ялгаа, чиг үүргийг судалж, тэдгээрийн үйл ажиллагаанд цогц байдлаар дүн шинжилгээ хийн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт боловсруулж, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас цаашид авах арга хэмжээтэй холбоотой 11 дүгээр тэмдэглэл гаргасан. Тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж байна. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| 58 | 90 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br>2021-02-11, № 46 | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А-1/354 дүгээр албан бичгээр төрийн | "Бүрэн хэрэгжсэн" - 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2. Коронавирусын халдвар (КОВИД-19)-т цар тахлын үед төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газруудыг хэмнэлтийн горимд шилжүүлж, шат дамжлага, чиг үүргийн давхардлыг арилгах замаар үйл ажиллагааны удирдлага, чиглэл, бүтэц, орон тоог оновчтой болгох, зардлыг бууруулах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Санал, дүгнэлтээ 2021 оны 4 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Ажлын хэсэг (Б.Жавхлан)-т даалгасугай. | өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 105 компани, үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захирал нарт Монгол Улсын Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу компани, үйлдвэрийн газруудыг хэмнэлтийн горимд шилжүүлж, зардлыг 10 хувиар бууруулах, бүтэц, орон тоог оновчтой болгох, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, шагнал урамшуулал олгохгүй байх, мөн хэмнэлтийн болон цар тахлын үеийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг ирүүлэх талаар албан даалгаврыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн өмчлөлийн хэлбэр, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, компанийн засаглал, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр холбогдох судалгаа, шинжилгээ, эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулж ажлын хэсэгт хүргүүлсэн. Ажлын хэсэг судалж үзээд, чиглэл болгосны дагуу цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулан Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанд танилцуулж, уг хуралдаанаас 17 дугаар тэмдэглэл гаргасан. | | |
| | | **ЕС-ын захирамж: 3 шийдвэрийн 3 заалт** | **100% - 1 заалт; 70% - 2 заалт; Хэрэгжилтийн хувь – 80.0%.** | | |
| **Найм. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 59 | 91 | **Албан татварын төлөх хугацааг сунгах тухай**<br><br>2019-04-10, №16<br><br>YIII.2. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрсний хэрэглээг хориглох арга хэмжээ авсантай холбогдуулан “Цогцолборыг шилжүүлэх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх тухай” Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолоор Батлан хамгаалах яамны мэдэлд шилжүүлсэн барилгын хийц үйлдвэрлэх хөделгөөнт цогцолбор (UBM)-ыг сайжруулсан түлшний үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг нөөцлөх барилга байгууламж барих болон бусад арилжааны зорилгоор ашиглахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Төрийн өмчийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br><br>Үүсээд байгаа нөхцөл байдлын талаар танилцуулж, чиглэл авахаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2020 оны А-1/617 дугаартай албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн ХЭГ/1555 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн.<br><br>Зээлийн барьцаанд байгаа хөрөнгийн өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэлгүйгээр балансаас балансад шилжүүлэх шийдвэр гаргах боломжгүй байгаа. Харин хөрөнгийг Батлан хамгаалах яаманд хүлээлгэн өгч хадгалуулж байгаа болно. | “Хэрэгжээгүй” – 0 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгав. | | | |
| | 92 | **Албан татварын төлөх хугацааг сунгах тухай**<br>2019-04-10, №16<br>YIII.3. Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM)-ын ашиглалтаас олох орлогыг Хөгжлийн банкны зээл, зээлийн хүүг эргэн төлөхөд зарцуулахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгав. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Өр төлбөрийн асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас хэрэгжих боломжгүй байгаа. Өр зээлийн барьцаанд байгаа уг тоног төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн төрийн өмчид бүртгэх боломжгүй.<br>Хөгжлийн банкны зээлийг хаах хүндрэлтэй асуудлаар Сангийн яаманд хүсэлт тавих, шаардлагатай бол Засгийн газрын хуралдаанд шийдвэрлүүлэх талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл өгсөн болно. Энэ чиглэлийг Батлан хамгаалах яаманд уламжилсан. Хөгжлийн банкнаас уг байгууламжийг зээлийн барьцаалбарт байгаа талаар мэдэгдсэн тул шийдвэрийг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч, хойшлогдож байсан болно.<br>Батлан хамгаалахын сайдын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/49 дугаар тушаалаар "Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн иж бүрдэл, түүний ажиллагааны талаар туршилт явуулж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг байгуулсан байна. Уг ажлын хэсгээр тухайн тоног төхөөрөмжийг ашиглах талаар судалж, анхны туршилт сургалтыг орох зорилготой.<br>Мөн Хөгжлийн банкны эзгээс тоног төхөөрөмж худалдан авахад зориулсан зээлийн төлбөрийг шийдвэрлэж балансаас балансад шилжүүлэх, Засгийн газрын 2017 оны 48 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах талаар хамтарч ажиллах тухай саналыг Батлан хамгаалах яаманд 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 2/440 тоот албан бичгээр санал хүргүүлсэн байна. | "Хэрэгжилт хангалтгүй" – 30 % | |
| 60 | 93 | **Хөрөнгө оруулалтын цэнхэр, ягаан тасалбараар хийгдсэн өмч хувьчлалын талаар хийсэн ажлын хэсгийн санал, дүгнэлтийн тухай**<br>2019-12-11, № 54<br>XXIX.1.2. Төрөөс төрийн өмчийн талаар болон өмч хувьчлал, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг тодорхой болгох, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын болон олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ**<br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 29 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, судалгаа хийх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн холбогдох баримт материалын хамт боловсруулж, ТӨБЗГ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хуулийн төсөлтэй ЗГХЭГ-ын дарга танилцаж байгаа бөгөөд яамдаас хуулийн төсөлд санал авахаар ажиллаж байна. Хуулийн | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | боловсруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т; | шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-д өргөн барих ажлыг ЗГХЭГ хариуцан ажиллаж байна.<br>Хуулийн төслийг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нартай хамтран боловсруулж, ажлын хэсгийн гишүүдийн гаргасан саналыг төсөлд тусгасан. | | |
| | 94 | **Хөрөнгө оруулалтын цэнхэр, ягаан тасалбараар хийгдсэн өмч хувьчлалын талаар хийсэн ажлын хэсгийн санал, дүгнэлтийн тухай**<br>2019-12-11, № 54<br>XXIX.1.3. Өмч хувьчлалын 1991-1996 оны нэгдсэн мэдээлэл, судалгааг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Архивын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Өмч хувьчлалын 1991-1996 оны нэгдсэн мэдээлэл, судалгааг бүрдүүлэх ажлын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Архивын ерөнхий газарт албан бичиг хүргүүлсэн боловч тодорхой ажил хийгдээгүй. | “Хэрэгжээгүй” – 0 % | |
| | 95 | **Хөрөнгө оруулалтын цэнхэр, ягаан тасалбараар хийгдсэн өмч хувьчлалын талаар хийсэн ажлын хэсгийн санал, дүгнэлтийн тухай**<br>2019-12-11, № 54<br>XXIX.1.4. Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид шилжсэн хөрөнгийн өнөөгийн байдал, орон нутгийн өмч хувьчлалын талаарх судалгааг гарган, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид шилжсэн хөрөнгийн өнөөгийн байдал, орон нутгийн өмч хувьчлалын талаарх судалгааг гарган, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга нарт чиглэл, судалгаа гаргах загварчлалыг хүргүүлсэн боловч нэг ч хариу ирээгүй байна. | “Хэрэгжилт хангалтгүй” – 30% | |
| 61 | 96 | **2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 26 дугаар тэмдэглэл**<br>2020-04-22, № 26<br>YII. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуужуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Засгийн газрын IX байранд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Засгийн газрын нийтлэг үйлчилгээний газраас тус байрыг дулааны тоолуураар хангасан байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгох;<br>2.Дулааны тоолуур худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийг төсөвт байгууллагын зарлагын хэмнэлт, давсан орлогоос холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэхийг Төсвийн захирагч нарт зөвшөөрөх; | | | |
| 62 | 97 | **2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр 48 дугаар тэмдэглэл**<br>2020-09-09, № 48<br>XI.1.4. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2016-2020 оны хөрөнгө оруулалт, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ**<br>Тэмдэглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сангийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баталсан “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2016-2020 оны эхний хагас жилийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хийх хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар болон Төрийн худалдан авах ажиллагааны газрын төлөөлөл бүхий нийт 19 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 10 дугаар сараас эхлэн 2021 оны 03 дугаар сарыг дуустал хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Монгол Улсад шинэ коронавирусын халдвар /covid-19/ илэрсэнтэй холбоотойгоор Засгийн газар, Улсын Онцгой Комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосонтой холбогдуулан хяналт шалгалтын хугацаа ийнхүү хойшилж сунгагдсан болно.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тус ажлын хэсэгт 3 мэргэжилтэн ажилласан. Сангийн сайдын баталсан удирдамжийн хүрээнд компанийн бараа материал, эргэлтийн бус хөрөнгө, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, компанийн ТУЗ-ийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, компанийн засаглалын талаар, нүүрсний өртөг, борлуулж буй үнэ зэргийг судлан шалгаж, шалгалтын ажлын тайланг боловсруулан Сангийн яаманд хүргүүлж тайлагнасан болно.<br>Сангийн яамнаас Ажлын хэсгийн тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газарт танилцуулах үүрэг хүлээж байгаа болно. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 63 | 98 | **2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр 52 дугаар тэмдэглэл**<br>2020-09-30, № 52<br>XYII.4.8. "АСА Консалтинг" ХХК-тай циркийн урлагийн мэргэжлийн удирдлага, үйл | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газарт Циркийн хувьчлалтай холбоотой холбогдох материал, судалгааг Архивын ерөнхий газраас авч хүргүүлсэн. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр, зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэйгөөр байгуулсан холбогдох гэрээний хэрэгжилтийг хангуулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Соёлын сайд С.Чулуун, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт. | | | |
| 64 | 99 | **2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр 58 дугаар тэмдэглэл**<br>2020-11-04, № 58<br>XYI.2. "Геологийн судалгааны төв" болон "Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ыг Үндэсний геологийн албаны харьяанд ажиллуулах боломжийг судлан саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Үндэсний геологийн алба (О.Чулуун), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн хувьд Үндэсний геологийн албаны харьяанд төсөвт үйлдвэрийн газар болгон ажиллуулах боломжгүй тул Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Үндэсний геологийн албатай уулзалт, ярилцлага хийсний үндсэн дээр "Геологийн төв лаборатори" ТӨҮГ, "Геологийн судалгааны төв" ТӨҮГ-ын дүрмийг шинэчлэн боловсруулж, УУХҮЯ болон Үндэсний геологийн албаны саналыг тусган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн болно. | "Хэрэгжих шатанд" - 70 % | |
| 65 | 100 | **2020 оны 12 дугаар сарын 9-ны өдөр 69 дугаар тэмдэглэл**<br>2020-12-09, № 69<br>Y.Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах замаар төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай, чирэгдэлгүй, оновчтой хүргэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгав. | **ТӨБЗГ – ТӨБАХ, МТА**<br>Төрийн цахим шилжилтийн бодлогын уялдааг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах талаар мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэлэлцүүлэгт оролцож саналаа өгсөн.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн програм хангамжийг боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад мэдээллийн сантай холбох арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2021 оны 04 сарын 07 өдрийн А/31 тоот тушаалаар байгуулан ажиллуулж байна. | "Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |
| 66 | 101 | **2021 оны 2 дугаар сарын 3-ны өдөр 8 дугаар тэмдэглэл**<br>2021-02-08, № 8 | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/32 дугаар тушаалаар "Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ-ыг УТҮГ болгох боломжийг судалж, санал дүгнэлт гаргах ажлын хэсгийг ЗГХЭГ, ХХМТГ болон | "Хэрэгжих шатанд" - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | I.3. "Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨААТҮГ-ыг улсын төсөвт үйлдвэрийн газар болгох боломжийг судалж, танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав. | "Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ-ын төлөөллийг оролцуулан байгуулсан.<br><br>Ажлын хэсэг "Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ-ыг УТҮГ болгох эрх зүйн ач холбогдол, эерэг ба сул талын харьцуулалт, улсын төсөвт үйлдвэрийн газар болгосноор санхүүгийн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, зохион байгуулалт болон санхүүгийн хүндрэл гарах эсэх, Засгийн газрын баталсан бодлогын баримт бичгүүдэд харилцаа холбоо, мэдээллийн технологийг хөгжүүлэх чиглэлээр туссан арга хэмжээний хүрээнд Мэдээлэл, технологийн үндэсний паркаас хийж, хэрэгжүүлсэн ажлын талаар дүгнэлт гаргах, цаашид төрөөс харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжлийн талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэхэд үйлдвэрийн газрын үүрэг, оролцоог тодорхой болгох талаар судалгаа шинжилгээг хийж, дүгнэлт, шийдвэрийн төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Уг хуралдаанаас Монгол Улсын Сангийн яамнаас санал авах шаардлагатай гэж үзсэн. Сангийн яамнаас Улсын төсөвт үйлдвэрийн газар болгох талаар саналаа ирүүлсэн тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 06 дугаар сарын 24-ний хуралдаанд асуудлыг дахин хэлэлцүүлж тэмдэглэл гаргаж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. | | |
| 67 | 102 | **2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл**<br><br>2021-02-17, № 11<br><br>XII.10. **Төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах** хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 43 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгээс төрийн өмчит хуулийн этгээд (улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төрийн өмчит компани, төрийн өмчийн оролцоотой компани)-ийн эрх зүйн байдал, зааг ялгаа, чиг үүргийг судалж, тэдгээрийн үйл ажиллагаанд цогц байдлаар дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ**<br><br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 29 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, судалгаа хийх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн холбогдох баримт материалын хамт боловсруулж, ТӨБЗГ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хуулийн төсөлтэй ЗГХЭГ-ын дарга танилцаж байгаа бөгөөд яамдаас хуулийн төсөлд санал авахаар ажиллаж байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-д өргөн барих ажлыг ЗГХЭГ хариуцан ажиллаж байна. | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Монгол Улсын Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн өөрчлөлттэй уялдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж, холбогдох хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нарт; | Хуулийн төслийг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нартай хамтран боловсруулж, ажлын хэсгийн гишүүдийн гаргасан саналыг төсөлд тусгасан.<br><br>Түүнчлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2021 оны ХЭГ/1405 тоот албан бичгээр ирүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалд тусгах саналыг боловсруулж, 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А-1/939 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |
| | 103 | **2021 оны 2 дугаар сарын 17-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл**<br><br>2021-02-17, № 11<br><br>XII.10. 3. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн үйлдвэрийн газруудын засаглалыг олон улсын түвшинд хүргэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой зохион байгуулалтын арга хэмжээ авч, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Дэлхийн банк болон бусад олон улсын байгууллагуудад хандан компанийн засаглалын зарчим болон төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын засаглалыг олон улсын түвшинд хүргэхэд анхаарах зүйл болон олон улсын туршлага судлах, зөвлөмж, чиглэл авахаар ажиллаж байна.<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалыг сайжруулах, олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд СЭЗС, "Компанийн Засаглалын хөгжлийн төв" ТББ-тай хамтран ажиллаж, "Монгол шуудан" ХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Монголын төмөр зам" ТӨХК, "Амгалан дулааны станц" ТӨХК, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК, "Мэдээлэл, холбооны сүлжээ" ХХК, "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК, "Дулааны хоёрдугаар цахилгаан станц" ТӨХК зэрэг 9 компанид засаглалын үнэлгээг хийлгэсэн.<br><br>Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийг газруудыг хэмнэлтийн горимд шилжүүлж, шат дамжлага, чиг үүргийн давхардлыг арилгах замаар үйл ажиллагааны удирдлага, чиглэл, бүтэц, орон тоог оновчтой болгох, зардлыг бууруулах, хөрөнгийг үр ашигтай зарцуулж, зардлыг хэмнэхэд анхаарч ажиллах чиглэлээр төрийн өмчит хуулийн этгээдүүдийн захирал, гүйцэтгэх захирал нарт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн А-1/354 дүгээр албан бичгээр албан даалгавр өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | "Хэрэгжих шатанд" - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 68 | 104 | **2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл**<br>2021-02-24, № 13<br>XI.2.1. "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Нийслэлийн орон сууцны корпораци" хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах замаар төрийн өмч давамгайлсан (жаран зургаан хувиас доошгүй) "Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци" хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Нийслэлийн орон сууцны корпораци" хувьцаат компанийг нийлүүлж, өөрчлөн зохион байгуулах асуудлыг нарийвчлан судалж, санал солилцож нэгдсэн байр сууринд хүрэх талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалантай хамтран зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Барилга, хот байгуулалтын сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагууд 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Сандагсүрэн болон бусад холбогдох албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулав. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А-1/534 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумьяабазарт уг асуудлаар хамтран ажиллах тухай хүсэлт хүргүүлсэн.<br>"Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци" ХХК байгуулах асуудлыг 2021 оны 04 сарын 29-ний өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд "Нийслэлийн орон сууцны корпораци" ХК-ийг татан буулгаж, шинэ байгууллагад нэгтгэх асуудлаар ажлын хэсгийн дүгнэлт гаргахаар шийдвэрлэсэн.<br>"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК нь шинээр байгуулагдах байгууллагын дүрэм, байгууллагын бүтэц бүрэлдэхүүний талаар Барилга, хот байгуулалтын яамтай хамтран тодорхой саналуудыг гаргаад байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдаж ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэн шийдвэр гаргасны дараа "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү асуудлыг хэлэлцэн зохих шийдвэр гаргана. | "Хэрэгжих шатанд" - 70% | |
| | 105 | **2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл**<br>2021-02-24, № 13<br>XI.2.3. "Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани шинээр байгуулахтай холбогдуулан "Төрийн орон сууцны корпораци" | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн нийт өр төлбөрийг шийдвэрлэх зорилготойгоор Монгол Улсын Хөгжлийн банкнаас шүүхийн шатанд шилжүүлээд байсан нийт 45.5 сая ам доллар буюу 124,172.4 сая төгрөгийн маргаанууд шийдвэрлэгдэх шатанд байна: | "Хэрэгжих шатанд" - 70% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Нийслэлийн орон сууцны корпораци" хувьцаат компанийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, шилжүүлэх, өр төлбөрийг хэрхэн барагдуулах талаар судалж, шийдвэрлүүлэх талаар тодорхой саналаа холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулан хэлэлцүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (С.Наранцогт)-д; | 1.Монгол Улсын Хөгжлийн банкны нэхэмжилсэн "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ /хуучнаар/-тай байгуулсан 3-0С-Б 2015-33 дугаартай Зээлийн гэрээг цуцалж, үндсэн зээл, зээлийн үндсэн хүүгийн төлбөрт нийт 36,212,725.75 ам.доллар буюу 98,522,514,520.62 төгрөгийг Хөгжлийн банкинд олгуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн шүүхийн шийдвэрээр "ТОСК" ХХК-иас 24,604,103,971 төгрөгийг зээлийн гэрээний үүрэгт хүүнд төлүүлэхээр, "Нью ярмаг хаусинг прожект" ХХК-иас 61,182,991,441 төгрөгийг гаргуулахаар, нэхэмжлэгчийн нэхэмжлэлээс 18,946,865,185 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Хамтран хариуцагч 3 компани давж заалдах шатны шүүхийн магадлалыг эс зөвшөөрч, Улсын Дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргасан байгаа.<br><br>2.Монгол Улсын Хөгжлийн банкны нэхэмжлэлтэй үндсэн зээл, зээлийн үндсэн хүү болон нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт нийт 9,398,540.36 ам.доллар буюу Монгол банкнаас зарласан тухайн үеийн ханшаар тооцож 25,649,932,438.09 төгрөгийг зээлдэгч "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-аас гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн Анхан шатны шүүхээс 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн шийдвэрээр нэхэмжлэгчийн шаардлага хангаж шийдвэрлэсэн.<br><br>3.Батлан хамгаалахын сайдын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/49 дугаар тушаалаар "Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн иж бүрдэл, түүний ажиллагааны талаар туршилт явуулж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийг байгуулсан. Мөн Хөгжлийн банкны зүгээс тоног төхөөрөмж худалдан авахад зориулсан зээлийн төлбөрийг шийдвэрлэж балансаас балансад шилжүүлэх, Засгийн газрын 2017 оны 48 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах талаар хамтарч ажиллах тухай саналыг Батлан хамгаалах яаманд 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 2/440 тоот албан бичгээр санал хүргүүлээд байна. | | |
| 106 | **2021 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 13 дугаар тэмдэглэл**<br><br>2021-02-24, № 13<br><br>XI.2.4. "Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийг орон сууцжуулахтай | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хариуцлагатай компани байгуулахтай холбогдуулан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийг орон сууцжуулахтай холбогдсон зорилт, арга хэмжээг компанийн дүрэмд хэрхэн тусгаж, уялдуулах саналаа танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт." | холбогдсон зорилт, арга хэмжээг "Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон компанийн дүрмийн төсөлд тусгахаар боловсруулж байна. | | |
| 69 | 107 | **2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл**<br><br>2021-03-10, № 17<br><br>XII.2.1. Төрийн өмчит үйлдвэрийн газар, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн өмчлөлийн хэлбэр, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, компанийн засаглал, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгав: 1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийн үндэслэл, зохицуулах харилцааны давхардал, зөрчлийг арилгах, өмчийн тухай ойлголтыг эдийн засаг нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан шинээр тодорхойлох, өмчийн удирдлагыг боловсронгуй болгох, өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх зүйн үндсийг тодорхой болгох, холбогдох хуулиудын уялдаа холбоог хангах судалгаа хийж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ХЭЗХ**<br><br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 29 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, судалгаа хийх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн холбогдох баримт материалын хамт боловсруулж, ТӨБЗГ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хуулийн төсөлтэй ЗГХЭГ-ын дарга танилцаж байгаа бөгөөд яамдаас хуулийн төсөлд санал авахаар ажиллаж байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-д өргөн барих ажлыг ЗГХЭГ хариуцан ажиллаж байна.<br><br>Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын статусын асуудлыг шийдвэрлэж, чадавх, үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийг тодорхой болгох асуудал тусгагдсан бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн өмчийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэх тухай зааж өгсөн. Түүнчлэн, Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь орон нутагт нэгжтэй байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан нь өнөөгийн Орон | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-;- | нутгийн өмчийн газрыг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах боломжийг бүрдүүлнэ гэж үзсэн. Иймээс хуулийн шинэчлэлийн хүрээнд хийгдэх уг асуудал хууль хэрхэн батлагдахаас шалтгаална.<br><br>Түүнчлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2021 оны ХЭГ/1405 тоот албан бичгээр ирүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл, үзэл баримтлалд тусгах саналыг боловсруулж, 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А-1/939 тоот албан бичгээр хүргүүлсэн. Компанийн засаглалын талаар "...төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал гэх тогтсон тодорхой загвар байж болох хэдий ч түүнийг бүтээх гол үндэслэл нь төр түүний хувьцааг эзэмшиж байгаа явдал гэдгийг ойлгож, тэрхүү хувьцааг олж авах, захиран зарцуулах, хувьцаанд ногдох эрхийг хэрэгжүүлэх механизмыг зөв тогтоох, энэ агуулгаар төр хувьцааг тооцоо, судалгааны үндсэн дээр тодорхой салбарт эзэмших, хувьцаа эзэмшигчийн ямар эрхээ аль байгууллагаар дамжуулж хэрэгжүүлэх хуваарилалт, хариуцлагын эргэх холбоо, тайлагнал, ил тод байдлыг хангах механизм"-ыг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар ТӨБЗГ-аас саналаа өгсөн болно. | | |
| | 108 | **2021 оны 3 дугаар сарын 10-ны өдөр 17 дугаар тэмдэглэл**<br><br>2021-03-10, № 17<br><br>XII.2.2. Төр, хувийн хэвшлийн зохистой харьцаа бүхий эдийн засгийн бүтцийг бүрдүүлэхэд анхаарч, цаашид төрөөс иргэдийн нийтлэг хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор бизнесийн үйл ажиллагаа эрхлэх салбар, чиглэлийг тодорхойлж, төрийн өмчит хуулийн этгээдийн зах зээл дэх оролцоо, чиг үүргийн талаар холбогдох яамдын саналыг албан ёсоор авч нэгтгэн боловсруулж, зохих санал, дүгнэлтийг 2021 оны II улиралд багтаан танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Төр, хувийн хэвшлийн зохистой харьцаа бүхий эдийн засгийн бүтцийг бүрдүүлэхэд анхаарч, цаашид төрөөс иргэдийн нийтлэг хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор бизнесийн үйл ажиллагаа эрхлэх салбар, чиглэлийг тодорхойлж, төрийн өмчит хуулийн этгээдийн зах зээл дэх оролцоо, чиг үүргийн талаар ангилж, холбогдох судалгааг гарган Ерөнхий сайдын 2021 оны 46 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсэгт хүргүүлсэн. Уг ажлын хэсэг холбогдох яамдын саналыг албан ёсоор авч нэгтгэн боловсруулж байгаа болно. УИХ-д энэ талаар Ерөнхий сайд мэдээлэл хийхээр бэлтгэсэн. | "Хэрэгжих шатанд" - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 70 | 109 | **2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл**<br>2021-03-24. № 19<br>II. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнг хэлэлцэн дэмжээд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, хууль, тогтоолд заасны дагуу эрх шилжүүлэн зохион байгуулах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгав. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журамын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 110,000,000 төгрөгөөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагаа 2021 оны 8 дугаар сарын 03 өдрөөс хэрэгжиж эхэлнэ. 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий тайланг маягтаар 2021 оны 06 сарын 14-ний өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |
| | 110 | **2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр тэмдэглэл**<br>2021-03-24. № 19<br>II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт байхгүй болно. | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |
| 71 | 111 | **2021 оны 3 дугаар сарын 31-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл**<br>2021-03-31. № 21<br>YII.6. Төрийн болон нийслэлийн өмчид байгаа бага, том оврын автобусны судалгааг гаргаж, автобусыг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд Улсын онцгой комиссын | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Төрийн өмчит төсвийн байгууллага, компаниудаас нийт 54 микроавтобус, фургон маркийн автомашиныг жолооч нарын хамт татан төвлөрүүлж, Улсын онцгой комиссын Шуурхай штабтай хамтран Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн тандалт судалгааны багт зориулан 3 сарын 31-ний өдрөөс эхлэн | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | мэдэлд шилжүүлэн ажиллуулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт даалгав. | ажиллуулж байна. Эдгээр автомашинтай холбоотой асуудлыг тухай бүр шийдвэрлэж байна.<br>Улсын онцгой комиссын Шуурхай штабын үйл ажиллагаанд төрийн өмчит хуулийн этгээдээс 15 суудлын автомашиныг түр хугацаагаар шилжүүлж, шуурхай дуудлага, бусад шаардлагатай ажилд дайчлан ажиллуулж байна.<br>Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх вакцинжуулалтын үйл ажиллагаанд Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газартай хамтран төрийн болон нийслэлийн өмчийн нийт 61 автобусыг татан төвлөрүүлж, Улсын онцгой комиссын мэдэлд ажиллуулж байна.<br>Татан төвлөрүүлсэн төрийн болон нийслэлийн өмчийн автомашины бүртгэл судалгаа, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна. | | |
| | 112 | **2021 оны 3 дугаар сарын 31-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл**<br>2021-03-31 № 21<br>YII.7. Төрийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газарт ашиглагдаж байгаа эмнэлгийн тусламжийн техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүртгэлийг гаргаж, 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд Улсын онцгой комиссын мэдэлд ашиглуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Эрүүл мэндийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн тушаалаар батлагдсан Коронавирусын халдвар (Ковид-19) оношилгоо, эмчилгээний түр зааврыг үндэслэж гаргасан Хөнгөн болон хүндэвтэр өвчтөний оношилгоо, эмчилгээнд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаа ирүүлэх тухай ТӨБЗГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А-1/647 дугаар албан бичгийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 12 хуулийн этгээдийн захирал нарт хүргүүлсэн. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 9 хуулийн этгээдийн ирүүлсэн 3 нэрийн 60 ширхэг тоног төхөөрөмжийн жагсаалтыг Улсын онцгой комиссын stock@shtab.gov.mn майл хаягаар 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| 72 | 113 | **2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр 22 дугаар тэмдэглэл**<br>2021-04-07 № 22<br>IX.3.2. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан цахим систем бүхий аргачлалын дагуу боловсруулах, холбогдох | **ТӨБЗГ – ЗУХ, Хэлтсүүд**<br>Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлсэн болно. | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бэлтгэл ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | | | |
| | | **Тэмдэглэл: 14 шийдвэрийн 23 заалт** | **100% - 3 заалт; 70% - 11 заалт; 30% - 2 заалт; 0% - 2 заалт; ХБ/ҮБ – 5 заалт; Хэрэгжилтийн хувь – 62.8%** | | |
| **Ес. Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 73 | 114 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19. № 2<br>1. Дор дурьдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1. Салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; | **ТӨБЗГ – МТА**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн програм хангамжийг боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад мэдээллийн сантай холбох арга хэмжээний танилцуулга, төсвийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 115 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19 № 2<br>1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх; | **ТӨБЗГ – МТА**<br>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт манай байгууллагаас иргэдэд үзүүлдэг үйлчилгээ байхгүй тул холбогдох маягтын дагуу мэдээллээ хүргүүлсэн. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 116 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19. № 2<br>1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх; | **ТӨБЗГ – ЗУХ, МТА**<br>Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийн талаар дотоод мэдээлэл, сурталчилгааг нийт албан хаагчдад хүргэн санаа бодлыг нь судлах, санал авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 117 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19. № 2 | **ТӨБЗГ – ЗУХ, МТА, Хэлтсүүд** | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх; | Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулах ажил үйлчилгээ одоогоор **ТӨБЗГ**-ын нэр дээр байхгүй болно. | | |
| | 118 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах; | **ТӨБЗГ – МТА**<br>Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх талаар судалгаа хийж байна. Цахим гарын үсэг нэвтрүүлэх талаар "Эйбл Софт" ХХК, Үндэсний дата төвийн төслийн багт хүсэлтээ илгээсэн болно. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| | 119 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.6. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах; | **ТӨБЗГ – МТА, Хэлтсүүд**<br>Одоогоор тус байгууллагаас цахим үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ байхгүй, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээнд холбосон үйлчилгээ үгүй тул төлбөр тооцооны асуудал гараагүй байна. | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |
| | 120 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.7. ХУР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах; | **ТӨБЗГ – МТА**<br>ХУР системд холбогдсон мэдээлэл байхгүй. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт холбогдох мэдээллүүдийг гаргаж өгч судалгаанд хамрагдсан. | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |
| | 121 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах; | **ТӨБЗГ – МТА**<br>Байгууллагын цахим хуудсанд байгууллагын удирдлагын нууцад үл хамаарах тушаал, тогтоол шийдвэрийг байршуулан олон нийтэд нээлттэй мэдээлдэг. Цахим хуудсанд 2017 оноос хойших мэдээллийн бааз үүссэн. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| | 122 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг "Төрийн албан бичиг солилцооны | **ТӨБЗГ – МТА**<br>Байгууллагын дотоод үйл ажиллагаанд Эйбл Софт ХХК-ийн вэб хандалт бүхий удирдлагын мэдээллийн цогц систем "Able" платформыг ашиглаж, албан хэрэг хөтлөлтийн бүртгэлийг хөтлөн дотоод мэдээлэл солилцоог хангаж, албан бичгийн | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нэгдсэн систем"-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох. | шийдвэрлэлтэд хяналт тавин ажилладаг. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан "Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг "Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем"-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох" гэсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн боломж нөхцөлийг судалж байна. | | |
| | | **Албан даалгавар: 1 шийдвэрийн 9 заалт.** | **100% - 1 заалт; 70% - 3; ХБ/ҮБ – 5; Хэрэгжилтийн хувь - 77.5%.** | | |

**(Нийт 9 төрлийн 73 шийдвэрийн 122 заалтын хэрэгжилтийг тайлагнав)**

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ